



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАЖ БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИТ, ҮР
ДҮН”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2024/31-1-ШТА-ГА

СУМДЫН ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛ, ХАМТАРСАН БАГИЙН АЖИЛЛАГАА
ХАНГАЛТГҮЙГЭЭС ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ ГАРСААР БАЙНА.

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт

мэдээллийг дараах хаягаар авна уу

Цахим хуудас: www.open.audit.mn

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Азбаяр

Утас: : 70442424 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn

Аудитор Д.Даваадорж

Утас: : 70442424 цахим хуудас: davaadorjb@audit.gov.mn

Баянхонгор хот 2024 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.tailan.audit.mn

Тайланг хянасан

Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор
Б.Мөнхбат
Аудитын менежер
М.Алтантуяа

Тайланг бэлтгэсэн:

Ахлах аудитор Б.Азбаяр
Аудитор Д.Даваадорж

2024 оны 10 дугаар сарын 25-
ны өдөр

Уг тайланг УАГ-ын
цахим хуудаснаас үзнэ үү:
www.open.audit.mn

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70442424 дугаарын утас,
70442584 дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь Төрийн
аудитын газар, Нутгийн
удирдлагын ордон,
Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум 64090,
Баянхонгор аймаг
Монгол Улс

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх
мэдэгдэл 4

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....5

**БҮЛЭГ 1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ
БУЙ БОДЛОГО, ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ ЭСЭХ?.....6**

**ДҮГНЭЛТ 1. ЗАСАГ ЗАХИРГААНЫ АНХАН ШАТНЫ НЭГЖИЙН
ТҮВШИНД ХҮҮХЭД ХАМГААЛАХ БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ БОЛОН
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРГИЙГ ЗААГЛАЛГҮЙ НЭГ АЛБАН ТУШААЛТАНД
ХАРИУЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ БАЙГААГААС ХЯНАЛТЫН
ТОГТОЛЦОО АЛДАГДАЖ ХҮҮХДИЙН ЭРХ ЗӨРЧИГДӨХ НЭГ ШАЛТГААН
БОЛЖ БАЙНА.6**

1.1 Хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоо нийгмийн хэрэгцээ
шаардлагад нийцсэн үү? /хангаж чадахаар байна уу?/.....6

1.1. Орон нутагт хүүхэд хамгааллын бодлогыг Монгол улсын урт
дунд хугацааны бодлогод уялдуулан баталж, нийгмийн зорилтод
бүлэгт чиглэн ажилласан байна.6

1.2. Аймгийн ХГБХХГ-ын орон тоог бүрэн нөхөөгүй, сумын хүүхдийн
төлөө зөвлөлтэй ажлын уялдаа холбоо муу байна.8

**БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ,
ТӨСӨВЛӨЛТ ҮР ӨГӨӨЖТЭЙ, ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ БАЙЖ ЧАДСАН ЭСЭХ?
11**

**ДҮГНЭЛТ 2. ХҮҮХЭД ГЭР БҮЛ ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫН ГАЗАР НЬ
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗАРДЛЫГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ҮНДЭСЛЭЛТЭЙ
ТООЦООГҮЙ, ХУВААРИЛАЛТ ОНОВЧТОЙ ХИЙГЭЭГҮЙГЭЭС ЗАРДЛЫГ
ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.11**

2.1. Хүүхэд хамгааллын санхүүжилт хүртээмжтэй байна уу?.....11

2.1. Хүүхдийн хамгаалал нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах
зардлын дийлэнх хэсгийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд,
залуучуудын төв болон түр хамгаалах байрны үйл ажиллагаанд
зарцуулж байна.11

2.2. Дүгнэлт.16

**БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ ЭСЭХ?22**

**ДҮГНЭЛТ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА
БОЛОВЧ КЕЙСИЙН ТОО БУУРАХГҮЙ БАЙНА.22**

3.1. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжиж буй үйл ажиллагаанд тавих
хяналтын тогтолцоо үр дүнтэй ажиллаж байна уу?.....22

3.1. Хүүхдийн эрх хамгааллын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж
байгаа боловч хяналтаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг тооцоогүй,
хяналтын үр нөлөө бүрэн гаргаагүй байна.22

3.2. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ нь
үр нөлөөтэй байна уу?27

3.2. Хүүхэд хамгааллын талаар холбогдох төрийн
байгууллагуудаас хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ нь үр нөлөөгөө
өгсөн байна.27

3.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр холбогдох төрийн
байгууллагууд зохих арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч кейсийн
тоо буурахгүй, хүүхдийн эрхийн зөрчил гарсаар байна.35

ДҮГНЭЛТ: 41

ЗӨВЛӨМЖ: 42

УАГ-Т ХҮРГҮҮЛЭХ САНАЛ43

Товчилсон үгийн тайлбар

АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АЗД	Аймгийн Засаг дарга
БЗХӨ	Бэлгийн замын халдварт өвчин
БТСГ	Биеийн тамир, спортын газар
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГНАГ	Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОУБ	Олон Улсын байгууллага
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
ХГБХХЕГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
ХХНЖ	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт
ХШҮХ	Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс
ХЭХЗХ	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Бодлогын баримт бичгийн уялдаа холбоо	6
Хүснэгт 2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургууль, цэцэрлэгт хамрагдагсдын судалгаа	8
Хүснэгт 3	Хүний нөөцийн судалгаа	11
Хүснэгт 4	Төсвийн төсөл боловсруулсан судалгаа	12
Хүснэгт 5	Баянхонгор аймгийн ХГБХХГ -ын төсвийн төсөл	12
Хүснэгт 6	Баянхонгор аймгийн ХГБХХГ -ын төсвийн төсөл	13
Хүснэгт 7	Баянхонгор аймгийн ХГБХХГ-ын 2019-2021 оны зардал	15
Хүснэгт 8	Баянхонгор аймгийн ХГБХХГ-ын 2022-2023 оны зардал	15
Хүснэгт 9	Баянхонгор аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 оны төсвийн гүйцэтгэл	16
Хүснэгт 10	Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан зардлын судалгаа	17
Хүснэгт 11	Төсөл, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгийн судалгаа	18
Хүснэгт 12	Статистик мэдээний нэгтгэл	19
Хүснэгт 13	2019-2021 оны төсвийн төслийн хэсгээс	21
Хүснэгт 14	108 утасны үйлчилгээний төвд ирсэн дуудлага	27
Хүснэгт 15	Эрсдэлийн үнэлгээний тайлан	28
Хүснэгт 16	Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн дуудлага	35
Хүснэгт 17	Хамтарсан багаас хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоо	36
Хүснэгт 18	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийн судалгаа	37
Хүснэгт 19	Гэмт хэрэгт хохирсон болон холбогдсон хүүхдийн судалгаа	38
Хүснэгт 20	ХГБХХГ-ын судалгааг статистик мэдээтэй харьцуулсан судалгаа	39

График

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны мэдээлэл	13
График 2	Шилэн данс мэдээлэл	17
График 3	Иргэдээс авсан санал асуулга	20
График 4	Ахлах ангийн сурагчдаас авсан судалгаа	27
График 5	Ахлах ангийн сурагчдаас авсан судалгаа	29
График 6	Хүүхдийн эндэгдлийн өсөлт бууралт	30
График 7	Нөхөн үржихүйн судалгаа	31
График 8	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгаа	35
График 9	ХЭХЗХ-с үйлчилгээ авсан хүүхэд	37
График 10	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгаа	39

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 угаар зүйлийн 7.1.2, 7.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаал, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай ” 2024 оны А/1 дүгээр тушаалыг дагуу хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт	Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан аймгийн ИТХ болон Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэв. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх; ➤ Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх; ➤ Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн Бодлогын хэлтэс, Баянхонгор аймгийн ХГБХХГ, Ерөнхий Боловсролын 28 сургууль, Цагдаагийн газар, Боловсролын газар, Засаг даргын холбогдох үйл ажиллагааг хамруулан шалгалаа.
Аудитын хязгаарлалт	Байхгүй.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	- Хүүхдийн Эрхийн Тухай Конвенц; - Монгол Улсын Үндсэн хууль; - Хүүхэд хамгааллын тухай хууль; - Хүүхдийн эрхийн тухай хууль - Гэр бүлийн тухай хууль; - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль; - Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль; - Боловсролын тухай хууль; - Төсвийн тухай хууль; - Шилэн дансны тухай хууль; - Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр; - Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл; - НҮБ болон Олон Улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмж
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Д.Даваадорж нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв. Аудитын талбарын үе шатны ажлыг 2024 оны 08 дугаар сарын 28-аас эхлэн гүйцэтгэсэн ба аудиторууд талбарын ажлын явцад тайлангийн төслийг бичиж, аудитын тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар 10 дугаар сарын 25-ны өдөр хэлэлцүүлж, тайланг баталгаажуулан ҮАГ, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.
Хүндрэл бэрхшээл	Байхгүй

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хүүхэд хамгааллын тухай хуулийг 2016 онд баталсан, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 онд баталж, 2024 оны 9 дүгээр сарын 1-ээс эхлэн дагаж мөрдөхөөр тусгажээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “хүүхэд хамгаалал” гэж нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг хэлнэ гэж заасан. Харин “хүүхэд хамгааллын үйлчилгээ” гэж хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор үзүүлж байгаа шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг хэлнэ” гэж тус заасан байна.

Аймгийн хүүхдийн тусламжийн тусгай дугаарт 2019 онд 82, 2020 онд 103, 2021 онд 146, 2022 онд 149, 2023 онд 72 нийт 552 дуудлага хүлээн авч 446 хаасан байна.

2019-2023 онуудад эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа, хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлж, аюулгүй байдлын хамгаалалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан нийт 289 хүүхэд байна.

Баянхонгор аймгийн ХГБХХГ нь гэр бүл, хүүхэд, залуучуудад ээлтэй бодлого хэрэгжүүлж, тэднийг хөгжих таатай орчин бий болгоход үндсэн зорилгоо тодорхойлсон.

Баянхонгор аймаг 2023 оны жилийн эцсийн байдлаар 18 аас доош насны 33,238 хүүхэд байгаа бөгөөд үүнээс 2,283 буюу 7 хувь нь эрсдэлт нөхцөлд байгаа нь улсын хэмжээнд 1 эрсдэлт бүлгийн хүүхдийн тоогоор 1 дүгээрт байна.

Унаач 11 хүүхэд мориноос унаж 2 хүүхэд бэртсэн ба энэ нь улсын дунджаас 1 дүгээрт, Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн тоо 2023 оны байдлаар 19 байгаа нь улсын хэмжээнд 2 дугаарт байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ ЭСЭХ?

ДҮГНЭЛТ 1. ЗАСАГ ЗАХИРГААНЫ АНХАН ШАТНЫ НЭГЖИЙН ТҮВШИНД ХҮҮХЭД ХАМГААЛАХ БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРГИЙГ ЗААГЛАЛГҮЙ НЭГ АЛБАН ТУШААЛТАНД ХАРИУЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ БАЙГААГААС ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО АЛДАГДАЖ ХҮҮХДИЙН ЭРХ ЗӨРЧИГДӨХ НЭГ ШАЛТГААН БОЛЖ БАЙНА.

1.1 Хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоо нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үү? /хангаж чадахаар байна уу?/

1.1. Орон нутагт хүүхэд хамгааллын бодлогыг Монгол улсын урт дунд хугацааны бодлогод уялдуулан баталж, нийгмийн зорилтод бүлэгт чиглэн ажилласан байна.

1.1.4 Хүүхэд хамгааллын талаар мөрдөж буй хууль тогтоомж, урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бодлогын баримт бичиг хоорондын уялдаа холбоо хангагдаж байна уу?

Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэхээр баталсан урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хоорондын уялдаа холбоо хангагдаж байна.

Монгол Улсын Их Хурлаас баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын "Хүний хөгжил" хоёрдугаар бүлгийн Зорилго 2-т "Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ", Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.8-д заасан "Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ" гэсэн бодлогын бичиг баримттай уялдаж байна.

Хүснэгт 1. Бодлогын баримт бичгийн уялдаа холбоо

Д/Д	Бодлогын баримт бичгийн зүйл заалт	Богино, дунд хугацааны бодлогын баримт бичиг	Хэрэгжилт
1	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050"-ийн "Хүний хөгжил" хоёрдугаар бүлгийн Зорилго 2-т "Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалттай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн	Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр • 55, 56 дугаар заалт "аймгийн хэмжээнд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн байна, • 13 дугаар заалт Хүүхдийн суралцах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлсэн байна, • 14 дүгээр заалт Хүүхэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөгжих, хамгаалуулах АЗД-ын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт • 2.7.1. Хүүхдийн хөгжил, төлөвшлийг сайжруулж, монгол өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг иргэн болгож, эцэг, эхийн үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлнэ, • 2.8.6. Хүүхдийн эрхийг дээдлэн "Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөрийг хэрэгжүүлж, аливаа	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хөгжүүлэх төвийн өдрийн үйлчилгээнд 74 хүүхэд, ердийн цэцэрлэгт 23 хүүхэд, ерөнхий боловсролын сургуульд 22 хүүхэд, тусгай цэцэрлэгт 3 хүүхэд, тусгай сургуульд 10 хүүхдийг хамруулсан. 402 эцэг эх, асран хамгаалагчид зөвлөгөө өгч хүүхдийн хөгжлийн ахиц өөрчлөлтийг үнэлсэн.

идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр” батлагдсан	хэлбэрийн хүчирхийлэл, дарамтад өртсөн иргэнийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйл ажиллагааг өргөжүүлнэ, • 1.1.4 “Ковид-19” вирусийн халдварын үеийн орон нутгийн эрсдэлийн үнэлгээг салбар дундын оролцоотой хийж, үр дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах, эрсдэлийг бууруулах” цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ, • 2.1.4. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлнэ, • 2.3.3. “Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд бүрд ээлтэй болгож, багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ, • 2.3.4. Сургууль, цэцэрлэгийн барилгын стандарт, норм нормативыг мөрдүүлж, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ.	158 хүүхэд эцэг эх асран хамгаалагчид сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн.
--	--	---

1.1.6 Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хүлээн авагчдын онцлог юу вэ?

Баянхонгор аймагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн хөтөлбөр түлхүү хэрэгжсэн байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 37 дугаар тогтоолоор “Хүүхдэд ээлтэй орон нутаг” дэд хөтөлбөрийг 2019-2020 онд хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын тогтоол болон аймгийн Засаг даргын захирамжаар 2019-2023 онд хүүхэд хамгааллын чиглэлээр дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.Үүнд:

- **2019 онд**- “Хүүхэд хамгаалал, өв тэгш хүмүүжлийн жил”
- **2020 онд** “Хүүхэд хамгаалалд эцэг эхийн үүрэг оролцоог хангуулах жил”
- **2021 онд** – “Залуучуудын өдөртэй болох тухай”
- **2022 онд**- “Хүүхдийн хөгжил, хүмүүжил, хамгаалалд хамтдаа-5Х”
- **2023 онд**- Хөдөлмөр зуслан

Аймаг орон нутгийн түвшинд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэгш оролцоог хангах, нийгэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг бодлогын хөтөлбөрт тусган аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл байгуулан ажилласан байна.

Баянхонгор аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын төвд аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 327-352 хүүхэд байгаагаас 2019-2023 онд 136-152 хүүхдийг хамгаалал, нөхөн сэргээх, нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх, тэгш оролцоог хангах зэрэг 4 хөтөлбөрт хамруулсан нь онцлог байна. Үүнд:

- *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нөхөн сэргээх хөдөлгөөн заслын арга зүйг хэрэгжүүлэх*
- *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чадамжид суурилсан боловсрол олгох амьдралын энгийн дадал хэвшил эзэмшүүлэх*
- *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн идэвхийг нэмэгдүүлж хамт олны дунд сэргээн засах*
- *Засан сайжирсан хүүхдийг энгийн хүүхдүүдийн дунд оруулж боловсрол эзэмшүүлэх.*

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамруулан сургах орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд НҮБ-ын хүүхдийн сангийн санхүүжилтээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхимыг Баянхонгор сумын Эрдэм, Номгон ахлах сургууль, Заг, Галуут, Өлзийт, Бөмбөгөр сумдын ЕБС дээр байгуулан хүүхдүүдийн хөгжлийг дэмжих, сэргээн засах, сурах орчин нөхцөлийг бүрдүүлсэн ба судалгаагаар 2022-2023 оны хичээлийн жилд сургуулийн насны 101, цэцэрлэгийн насны 38 хүүхэд суралцаж байна

Хүснэгт.№2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургууль, цэцэрлэгт хамрагдагсдын судалгаа

Хичээлийн жил	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Сургууль суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	115	105	105	101
Цэцэрлэгт хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	39	40	38	38

Эх сурвалж: Боловсролын статистик мэдээ

1.2. Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагууд хүний нөөцийн хүртээмжтэй байдлыг хангаж, харилцан уялдаатай ажиллаж чадаж байна уу?

1.2. Аймгийн ХГБХХГ-ын орон тоог бүрэн нөхөөгүй, сумын хүүхдийн төлөө зөвлөлтэй ажлын уялдаа холбоо муу байна.

1.2.2 ХҮҮХЭД, ГЭР БҮЛ ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ ЧАДАЖ БАЙНА УУ?

Аймгийн Хүүхэд гэр бүл, хөгжил хамгааллын газар нь хууль, дүрмээр хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүүхдийн төлөө зөвлөлд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байна.

Баянхонгор аймгийн ИТХ -ын тэргүүлэгчдийн 2016 оны 10 сарын 28-ны өдрийн хурлын 113-р тогтоолоор Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийг байгуулсан бөгөөд аймгийн Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газар нь тус зөвлөлийн ажлын албаны үүргийг хэрэгжүүлж байна.

Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийг Аймгийн Засаг даргын орлогч, сумын Хүүхдийн төлөө зөвлөлийг сумын Засаг дарга тус тус удирдан ажиллаж байна.

Сумын хүүхдийн төлөө зөвлөл болон хамтарсан багийг сумын Засаг дарга удирдан ажиллаж байгаа нь бодлого боловсруулах болон хэрэгжилтийг хангаж ажиллах асуудал нь эрх зүйн зохицуулалтаар нэг албан тушаалтанд байгаа нь хяналтын тогтолцоо сул байх эрсдэлийг үүсгэж байна.

Аймгийн хүүхдийн төлөө зөвлөл нь хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөндөө хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, салбар дундын уялдаа холбоо хангах чиглэл, зорилгыг тусгасан байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн 20 суманд сумын Засаг даргаар ахлуулсан хүүхдийн төлөө зөвлөл ажиллаж байгаа бөгөөд аймгийн ХГБХХГ-аас тайлант хугацаанд 28 зөвлөмж, зөвлөгөө өгсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй үйл ажиллагаа нь идэвхгүй байна.

Тухайлбал: Аудитаар Баян-Овоо, Баян-Өндөр, Богд сумын хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг шалгахад Хүүхэд хамгааллын талаар хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө батлаагүй, зөвлөлийн нарийн бичгийн дарга хуульд заасан үүргээ хэрэгжүүлээгүй, бүх сумд зөвлөлийн үйл ажиллагааны тайланг аймгийн ХГБХХГ-т тайлагнаагүй байна.

- Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.1 дэх заалт, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн 20.1 дэх заалтад тухайн сум, баг, хорооны Засаг дарга нь хүүхдийн төлөө зөвлөлийг тэргүүлнэ, хамтарсан багийг ахална гэж зааснаас шалтгаалж сумын Засаг дарга “Хүүхдийн төлөө зөвлөл”, “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг салгаж хэрэгжүүлээгүй байна.

Иймд сумдын хүүхдийн төлөө зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө тайланг авч хэрэгжилтийг тооцож байх албан шаардлагыг аймгийн ХГБХХГ-т хүргүүлэв.

Баянхонгор аймгийн ХГБХХГ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан 7 төрлийн чиг үүргийг дараах байдлаар хэрэгжүүлж ажилласан байна.Үүнд:

1. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлох чиг үүргийн хүрээнд хүүхэд хамгааллын мэдээллийн санг 129 үзүүлэлтээр эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг нэгтгэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

2. Төрийн байгууллага, хуулийн этгээд, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх чиг үүргийн хүрээнд төрийн болон, хууль сахиулах байгууллагын алба хаагч нарыг чадавхжуулах, хүүхдийн эрхийн мэдлэг мэдээлэл олгох чиглэлийн арга зүйн сургалтыг тогтмол хийж ирсэн байна. Үүнд:

- Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасгийн алба хаагч, сумдын хэсгийн төлөөлөгч нарт жилд 3-4 удаа хүүхдийн эрхийн талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран албадлагын арга хэмжээ авсан хүүхдүүдэд сар бүр сургалт, нөлөөллийн арга хэмжээ авч ажилласан байна

3. Хүүхдийн эрхийн тухай хууль болон энэ хуулийн хэрэгжилтэд гурван жил тутамд нэгээс доошгүй удаа анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийн хүрээнд энэ хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ хийсэн.

4. Нийгмийн ажилтан, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ирсэн. Үүнд:

Хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхдийн элч зэрэг хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийг мэргэжлийн арга зүйгээр ханган 2019-2023 онд зөвлөн туслах үйлчилгээг жилд 1-2 удаа үзүүлж 78 удаагийн зөвлөмж чиглэлийг өгсөн байна.

5. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаарх мэдээллийн сан бүрдүүлж, баталсан аргачлалын дагуу эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдийн халамж, хамгаалал үйлчилгээний талаар бүртгэл хөтөлж, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх чиг үүргийн хүрээнд аймгийн хэмжээнд 29 хамтарсан багаар дамжуулан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн мэдээллийн санг бүрдүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байна.

6. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд харагчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулж, гэр бүлийн болон хүүхдийн эрхийн эсрэг хүчирхийлэл үйлдэж шүүхээр албадан сургалт авах

шийдвэр гарсан иргэдэд Цагдаагийн газартай хамтран сард 1 удаа сургалтыг зохион байгуулж ажилласан байна.

7. Гэр бүлээсээ дайжсан, эсхүл эцэг, эх, асран хамгаалагчийн халамж анхаарал, хараа хяналтаас гадуур байгаа хүүхдийг бүртгэх, судалгаанд авах, гэр бүлд нэгтгэх ажлыг орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд аймгийн хэмжээнд гэр бүлээсээ дайжсан хүүхэд байхгүй ба хараа хяналтгүй хүүхдэд хамтарсан багууд хүүхэд хамгаалал, урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байна.

1.2.5 Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээлэл хаана нэгтгэгддэг вэ? Мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн эсэх?

Аймгийн ХГБХХГ нь Хүүхэд эрх хамгааллын статистик үзүүлэлтээр мэдээллийн санг бүрдүүлсэн байна.

Орон нутгийн анхан шатны нэгж сум багаас эрсдэлд нөхцөлд байгаа, хууль зөрчиж гэмт хэрэгт холбогдсон, хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн талаар бүртгэл, судалгааг гарган улирал, хагас жил, жил эцсээр нэгтгэн Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын ерөнхий газарт хүргүүлэн ажиллаж байна.

Хамтарсан багуудын нийгмийн бодлогын ажилтан, багийн Засаг дарга, сургуулийн нийгмийн ажилтан зэрэг анхан шатны нэгжүүдээр дамжуулан Монгол улсын үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А145 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу 2015-2021 он хүртэл, 2022 оны А/172 тоот тушаалаар батлагдсан “Хүүхдийн эрх хамгааллын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал” - аар 2022 оноос эхлэн мэдээллийн санг үүсгэсэн байна.

1.2.6 Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хүний нөөц тогтвортой, орон тоо хүрэлцээтэй, мэргэшсэн албан хаагчид ажилладаг эсэх?

Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газар нь 2022-2023 онд хүүхэд хамгааллын ажилтны орон тоо дутуу, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд тус салбарт дунджаар 8-15 жил ажилласан, мэргэшсэн албан хаагчид ажиллаж байна.

Баянхонгор аймгийн ХГБХХГ нь 2022, 2023 онуудад батлагдсан орон тоо дутуу ажилласан байна.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын даргын тушаалаар 2019-2021 онд 18 орон тоогоор үйл ажиллагаа явуулахаар байгууллагын бүтцийг баталсан ба үүнээс хүүхэд хамгааллын мэргэжилтэн 2 байна. Хүүхэд хамгааллын мэргэжилтэн нь Гэр бүл судлаач мэргэжлээр магистр, хүүхдийн эрхийн улсын байцаагч 2 байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны А/58 тоот тушаалаар бүтэц орон тоог 23 болгож баталсан бөгөөд үүнд хүүхэд хөгжил, хамгаалал хариуцсан ахлах мэргэжилтэн 1, хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн 1, хүүхдийн эрхийн улсын байцаагч 1 болж хүүхэд хамгааллын орон тоог 1-ээр нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт №3 Хүний нөөцийн судалгаа

Он	Батлагдсан орон тоо	Ажиллаж байгаа орон тоо	Үүнээс Нийгмийн ажилтан	Сэтгэл зүйч	Бусад	Зөрүү
1	2	3	4	5	6	7=(3-2)
2019	18	18	1	1	16	0
2020	18	18	2	1	15	0
2021	18	18	1	1	16	0
2022	23	21	2	1	18	-2
2023	23	21	2	1	18	-2

Тус газар нь 2023 оны 5 дугаар сар хүртэл батлагдсан орон тоогоор бүрэн ажилласан ба 9 сараас хүүхдийн эрхийн улсын байцаагч хүүхдийн хөгжил хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтний ажлыг хавсран гүйцэтгэж байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар 33,079 хүүхэд байгаагаас хүүхэд хамгааллын үйлчилгээ авах шаардлага бүхий эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 2283 хүүхэд байна.

Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хүүхдийн хөгжил, хамгаалал хариуцсан ахлах мэргэжилтнийг хавсран гүйцэтгэж байгаа нь өөрийн үндсэн ажил үүргээ гүйцэтгэх боломж хязгаарлагдаж байна.

БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВЛӨЛТ ҮР ӨГӨӨЖТЭЙ, ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ БАЙЖ ЧАДСАН ЭСЭХ?

ДҮГНЭЛТ 2. ХҮҮХЭД ГЭР БҮЛ ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫН ГАЗАР НЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗАРДЛЫГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТООЦООГҮЙ, ХУВААРИЛАЛТ ОНОВЧТОЙ ХИЙГЭЭГҮЙГЭЭС ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.

2.1. Хүүхэд хамгааллын санхүүжилт хүртээмжтэй байна уу?

2.1. Хүүхдийн хамгаалал нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах зардлын дийлэнх хэсгийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын төв болон түр хамгаалах байрны үйл ажиллагаанд зарцуулж байна.

2.1.1. Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, зардлыг судалгаанд үндэслэн үр дүнтэй тооцож төлөвлөсөн үү?

Төсвийн төсөлд хүүхэд хамгаалалд зориулсан зардлыг үндэслэлтэй тооцоогүй байна

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018 оны 37 дугаар тогтоолоор “Хүүхдэд ээлтэй орон нутаг” дэд хөтөлбөр, Баянхонгор аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2021-2024 оны засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, “Хүний хөгжил, нийгмийн бодлого” гэсэн бүлэг заалт оруулж хүүхэд хөгжил, хамгааллын хэрэгжүүлэх бодлого чиглэлийг тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл иргэн- Ирээдүйн үнэт зүйл
- Идэвхтэй амьдрал – Чийрэг иргэн
- Боловсролын чанар- хөгжлийн тулгуур
- Шинжлэх ухаан технологи, инноваци
- Халамжаас – Хөдөлмөрт
- Соёлтой иргэн-Нийгмийг түүчээлнэ
- Хонгорын иргэн-Хонгорын баялаг

Дээрх зорилтын хүрээнд төсвийн төсөлд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар жилд дунджаар 15-16 төсөл арга хэмжээг 563,000-2,036.200 мянган төгрөгөөр хэрэгжүүлэхээр аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсээс санал хүргүүлснээс нийт 3,302,500.0 мянган төгрөгийн 40 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аар баталсан байна.

Хүснэгт № 4 Төсвийн төсөл боловсруулсан судалгаа

№	Үзүүлэлт	2021				2022				2023			
		Төсвийн төсөлд өгсөн санал		Батлагдсан		Төсвийн төсөлд өгсөн санал		Батлагдсан		Төсвийн төсөлд өгсөн санал		Батлагдсан	
		төсөл арга хэмжээний тоо	мөнгөн дүн	төсөл арга хэмжээний тоо	мөнгөн дүн	төсөл арга хэмжээний тоо	мөнгөн дүн	төсөл арга хэмжээний тоо	мөнгөн дүн	төсөл арга хэмжээний тоо	мөнгөн дүн	төсөл арга хэмжээний тоо	мөнгөн дүн
1	Эрүүл иргэн-Ирээдүйн үнэт зүйл					1	20	1	20				
2	Идэвхитэй амьдрал – Чийрэг иргэн	2	200	2	200	3	280	3	280	1	80	1	80
3	Боловсролын чанар-хөгжлийн тулгуур	4	80	4	80	8	695.4	8	695.4	10	1767.2	10	1546.1
4	Шинжлэх ухаан технологи, инноваци												
5	Халамжаас – хөдөлмөрт									1	11	1	11
6	Соёлтой иргэн-Нийгмийг түүчээлнэ	3	140	3	140	1	20	1	20	1	110	1	110
7	Хонгорын иргэн-Хонгорын баялаг	6	143			2	52	2	52	3	68	3	68
	Нийт	15	563	9	420	15	1067.4	15	1067.4	16	2036.2	16	1815.1

Эх сурвалж: ХГБХХГ-ын төсвийн төслөөс

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь төсвийн төслийг 2019 онд 680,892.8 мянга, 2020 онд 711,280.0 мянга, 2021 онд 880,695.3 мянга, 2022 онд 896,189.4 мянга, 2023 онд 971,351.2 мянган төгрөгөөр тооцон Төсвийн тухай хуулийн дагуу жил бүрийн 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-т хүргүүлсэн.

Хүснэгт № 5 Баянхонгор аймгийн ХГБХХГ-ын төсвийн төсөл

мянган төгрөг

Он	Төсвийн төсөл	Үүнээс: Хүүхэд хамгаалалд зориулсан	Батлагдсан төсөв	Үүнээс: Хүүхэд хамгаалалд зориулсан
2019	680,895.8	298,924.8	496,984.2	384,472.2
2020	711,280.0	384,472.2	634,506.0	472,647.3
2021	880,695.3	500,000.0	493,228.2	282,647.3
2022	896,189.4	500,000.0	631,622.9	363,951.8
2023	971,351.2	610,421.8	1,258,045.3	538,286.0

Эх сурвалж: ХГБХХГ-ын 2019-2023 оны төслийн төсөл

Дээрх төсвийн төсөлд хүүхэд хамгаалалд зориулсан зардлыг төлөвлөхдөө дараах байдлаар төлөвлөжээ.

Аудитын илрүүлэлт

• 2019-2021 оны төсвийн төсөлд хүүхэд хамгааллын зардал тооцсон үндсэн мэдээллийн тоо хэмжээнд өөрчлөлт оруулаагүй, хүснэгтэн мэдээлэл тооцооллын алдаатай, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төв, Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ

ТББ-дын төсвийн төслийг хүүхэд хамгааллын төсөвт оруулан тооцохгүйгээр тусад нь дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн.

- 2022 оны төсвийн төсөлд хүүхэд хамгааллын зардлын задаргаа хийгээгүй.
- 2023 онд хөтөлбөр арга хэмжээ хүрэх үр дүнгээр төлөвлөсөн боловч мөнгөн дүнг задлаагүй төлөвлөсөн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.12-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчимтай нийцэхгүй байна.

Иймд байгууллагын төсвийн төслийг боловсруулахдаа зардлын гүйцэтгэл, тоо мэдээ, судалгаанд суурилсан иж бүрэн төсвийн төслийг бэлтгэн дээд шатны төсөв захирагчид хүргүүлж байх албан шаардлагыг аймгийн ХГБХХГ-т өгөв.

2.1.2. Хүүхэд хамгааллын төсөв хөрөнгө нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэж чадаж байна уу?

Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь хүүхдийн эрхийг зөрчлийг бууруулахад хувь нэмрээ өгч байна.

Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хүмүүжлийн эерэг хандлагын сургалт, нөлөөлөл, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдтэй ажиллах, хамгаалах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хүүхдийн хөгжлийн дэмжих уралдаан тэмцээн зохион байгуулж ажилласан байна.

Хүснэгт№ 6 Баянхонгор аймгийн ХГБХХГ -ын төсвийн төсөл

№	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Он				
		2019	2020	2021	2022	2023
1	Хүмүүжлийн эерэг хандлага сургалт	37,267.9	62,791.7	29,612.0	86,561.9	24,584.0
2	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдтэй ажиллах, хамгаалах	31,381.3	31,811.6	9,963.0	6,502.1	2,400.0
3	Хүүхдийн хөгжлийн дэмжих уралдаан тэмцээн зохион байгуулах	31,816.7	5,823.0	8,874.0	9,912.2	23,263.2
	Дүн	100,465.9	100,426.3	48,449.0	102,976.2	50,247.2

Эх сурвалж: /Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газар/

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос 2019-2023 онд нийт 1005 хүүхэд зөвлөн туслах үйлчилгээг авсан байна.

График №1 Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны мэдээлэл



Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээний талаар товч дурдвал:

- Эрүүгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн бусдын эд зүйлийг хулгайлах гэмт хэрэг, зөрчилд холбогдсон нийт 7 хүүхдийг мэдээллийн санд бүртгэн хүүхэд бүрд үнэлгээг хийж, аймгийн Цагдаагийн газарт хүүхдийн зан байдлаар тодорхойлолт гаргаж хамтран ажилласны үр дүнд 6 хүүхдийг гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлж, 1 хүүхэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдаж, зан байдлыг засах сургаалтанд хамруулсан байна.
- Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах салбар комисс 0-16 насны 164 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоож, дүгнэлт гаргасан. Шинээр асаргааны тэтгэмжид 8 хүүхэд, асаргааны тэтгэмжийн сунгалт 69 хүүхэд, асаргааны тэтгэмж шаардлагагүй 18 хүүхдийг бусад нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах боломжтой талаар зөвлөгөө өгч ажилласан.
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хараа хяналтгүй хүүхдийн мэдээллийн сан үүсгэж, эрсдэлийн бүртгэлд хамрагдсан сум бүрээс 19 хүүхэд, Баянхонгор сумын 9 багийн 171 хүүхэд, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төвөөс 15 нийт 548 хүүхэд даатгалд хамруулсан.

2020 онд

- Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо 5 удаа хуралдаж 16 кейс дээр ажиллаж гэмт хэргийн хохирогч болсон 8 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон хүүхдийн эрхийг хамгаалан ажилласан байна
- Ковид-19” вирусийн халдвар дэлхий нийтээр тархаж хүнд нөхцөлд 4 сумын 60 өрхөд хүнсний тусламж, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран 261 өрхөд 100 долларын тусламж үзүүлсэн.

2021 онд

- “Хамгаалагдсан 100 хүүхэд” зорилтыг дэвшүүлэн 20 сумын сэтгэц зан байдлын хувьд өөрчлөлттэй, гэмт хэрэг зөрчилд холбогддог, гэр бүлийн хүчирхийлэлд байнга өртдөг, бэлгийн хүчирхийлэлд өртөж хохирсон 100 хүүхдэд СЭМҮТ-ийн сэтгэл засалч эмч нараар дүгнэлт гаргуулан, нийгмийн ажилтан, эцэг эх асран хамгаалагч нарт цаашид хүүхэдтэй хэрхэн ажиллах талаар зөвлөгөө өгч, эрүүл мэнд, халамж, боловсрол, хөгжил, хамгааллын үйлчилгээнд холбон зуучилсан байна
- Бэлгийн хүчирхийлэлд 8 жилийн турш өртсөн 14 настай охиныг Улаанбаатар хотын “Ид шидийн орон”-д хүргэн хүүхдийн эрсдэлийн болон гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, PCR шинжилгээний хариу, эмчилгээний карт, төрсний гэрчилгээний хуулбар, холбон зуучлах үйлчилгээний маягтын хамт хүргэж, нууцын гэрээ, хариуцлагын гэрээ байгуулан, сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэн гэр бүлд нь эргэн нэгтгэсэн.

2022 онд

- Гэмт хэргийн хохирогч болсон 12 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон хүүхдийн байцаалтад 14 удаа, шүүх хуралд 5 удаа оролцон эрхийг хамгаалан ажилласан.

2023 он

- Гэрлэх ёслолын ордонд “Гэр бүлд зөвлөгөө өгөх” төвийг байгуулан сэтгэл зүйн зөвлөгөөг өгч ажиллаж байгаа ба гэмт хэргийн хохирогч, холбогдогч, албадлагын арга хэмжээ авагдсан, бусад асуудлаар хандсан нийт 71 хүүхдэд зөвлөгөө өгч ажилласан.
- “Хүүхдэд ээлтэй бизнесийн зарчим” үзэл санааг түгээх, “Хүүхэд эрхэм хэрэглэгч” нөлөөллийн ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд улсын байцаагчийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагуудтай зохион байгуулж ажилласан. Хяналт шалгалтад сүм хийд-17, уул уурхай-12, цэцэрлэг-68, сургууль-58, дотуур байр-21, хүүхэд харах үйлчилгээ-3, хүнсний худалдаа эрхэлдэг худалдааны төвүүд-78, хүүхдийн тоглоомын талбай, тоглоомын үйл ажиллагаа эрхэлдэг газар-15 нийт 272 нэгж хамрагдаж хараа хяналтгүй хүүхдийг илрүүлсэн. Шалгалтаар хүүхдийн эрх зөрчсөн зөрчил илрээгүй болно.

2.1.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай нөөцийг оновчтой тодорхойлж, зардлыг хуваарилж чадаж байна уу?

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдтэй ажиллах, хамгаалах, хүүхдийн хамгаалал нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах зардлыг оновчтой хуваарилж чадахгүй байна.

Баянхонгор аймгийн ХГБХХГ нь ГБЗХГ-ын дарга, Баянхонгор аймгийн ГБХЗХГ-ын дарга нарын хооронд байгуулсан “Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийг үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх гэрээ”-г үндэслэн 2019-2021 онд хүүхэд хамгаалал, гэр бүл, залуучуудын хөгжлийн төв байгуулах, төвөөр дамжуулан үйлчилгээ үзүүлэх зэрэг арга хэмжээг нэгтгэн 83115 “Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд” арга хэмжээнд төлөвлөн зарцуулж байсан бол 2022 оноос эхлэн 72209-“Залуучууд болон оюутнууд”, 72212-“Гэр бүлийн хөгжил хамгаалал хөтөлбөр”, 72207-“Хүүхдийн хөгжил хамгаалал” хөтөлбөр 80236-“Эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ”, 80237-“Хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээний зардал”, 80238-“Урьдчилсан сэргийлэх арга хэмжээ” болгон хөтөлбөрүүдийг салгаж баталснаар хүүхэд хамгааллын төсөв, гүйцэтгэлийг тусад нь тайлагнах бололцоо бүрдсэн байна.

Хүүхэд хамгааллын хөтөлбөр арга хэмжээний зардлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна.

Хүснэгт№:7 Баянхонгор аймгийн ХГБХХГ-ын 2019-2021 оны зардал /мян,төг/

Үзүүлэлт	2019	2020	2021	Нийт	Хувь
Нийт зардлын гүйцэтгэл	496,566.4	632,290.2	455,964.2	1,584,820.8	
83115 Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	356,134.3	472,511.1	282,647.3	1,111,292.7	70%
Гэр бүл залуучууд	53,488.2	145,155.6	55,054.0	253,697.8	23%
Хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх	35,680.0	49,279.2	13,314.8	98,274.0	9%
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төв ТББ	80,000.1	97,650.0	90,000.0	267,650.1	24%
Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ ТББ	86,500.0	80,000.0	75,829.5	242,329.5	22%
Урьдчилан сэргийлэх	100,466.0	100,426.3	48,449.0	249,341.3	22%

2019-2021 онд Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр арга хэмжээнд нийт зардлын 70 хувийг зарцуулсан ба үүнээс хүүхэд хамгааллын урьдчилсан сэргийлэх арга хэмжээний зардалд 22 хувь, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын төв, нэг цэгийн үйлчилгээний зардалд 46 хувь, хүүхэд хамгааллын нөхөн сэргээх зардалд 9 хувийг зарцуулсан байна.

Хүснэгт№: 8 Баянхонгор аймгийн ХГБХХГ-ын 2022-2023 оны зардал /мян,төг/

Үзүүлэлт	2022	2023	Нийт	Хувь
Нийт зардлын гүйцэтгэл	601,447.9	857,695.8	1,459,143.7	
Хүүхэд хамгааллын зардал	327,977.8	397,676.5	725,654.3	50%
80236 Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ	5,002.5	3,523.5	8,526.0	1%
80237 Хамгаалал, нөхөн сэргээх	219,999.2	343,905.8	563,905.0	78%
Хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх	44,999.2	168,294.6	213,293.8	29%
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төв ТББ	100,000.0	95,266.2	195,266.2	27%
Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ ТББ	75,000.0	80,345.0	155,345.0	21%

80238 Урьдчилан сэргийлэх	102,976.1	50,247.2	153,223.3	21%
---------------------------	-----------	----------	-----------	-----

2022-2023 онд хүүхэд хамгааллын хөтөлбөр арга хэмжээнд нийт зардлын 50 хувийг зарцуулсан ба үүнээс хүүхэд хамгааллын урьдчилсан сэргийлэх арга хэмжээний зардалд 21 хувь, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын төв, нэг цэгийн үйлчилгээний зардалд 48 хувь, хүүхэд хамгааллын нөхөн сэргээх зардалд 29 хувийг зарцуулсан байна.

2.2. Хүүхэд хамгаалалд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл үр дүнтэй, хяналттай байна уу?

2.2. Хүүхэд хамгаалалд төлөвлөсөн төсвийг арга хэмжээний зориулалтаар гүйлгэн зарцуулсан байна.

2.2.1. Хүүхэд хамгааллын чиглэлээр зарцуулсан санхүүжилт, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан уу?

Хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх үйл ажиллагааны зардлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд зарцуулсан байна.

Баянхонгор аймгийн ХГБХХГ нь 2019-2023 онд 3,080,005.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 3,043,964.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт №9 Баянхонгор аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 оны төсвийн гүйцэтгэл /мян,төг/

Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хувь
2019	496,948.4	496,566.4	99.9%
2020	634,506.0	632,290.2	99.7%
2021	461,803.7	455,964.2	98.7%
2022	615,265.4	601,447.9	97.8%
2023	871,481.5	857,695.8	98.6%
	3,080,005.0	3,043,964.5	

Хүүхэд хамгааллын зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримт, гэрээ, тушаал холбогдох баримттай тулган шалгахад дараах зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт

- 2020 онд 72207-“Хүүхдийн хөгжил хамгаалал” хөтөлбөр 83115 “Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд” арга хэмжээний зардлаас 49.9 сая төгрөгийг гэр бүлийн зөвлөгөө өгөх төвийн тохижилтод зарцуулсан.
- 2023 онд хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх зардлаас 36.4 сая төгрөгийг хамтарсан багийн өдөрлөг, “Оролцъё хөгжье хямгалъя” сэдэвт урьдчилсан сэргийлэх арга хэмжээний зардалд зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан А/23, 27 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив” журмын гурав” Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал тооцох” заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг Баянхонгор аймгийн ХГБХХГ-ын Н.Мэндбаярт хүргүүлэв.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын ихэнх хэсгийг сургалт, нөлөөллийн ажилд зарцуулж, эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдүүдтэй ажиллах, хамгаалахад 19 нь зарцуулж байгаа нь төсвийн зарцуулалт оновчтой бус байна.

Хүснэгт № 10 Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан зардлын судалгаа

№	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Он					Дундаж
		2019	2020	2021	2022	2023	
1	Хүмүүжлийн эерэг хандлага сургалт	37%	63%	61%	84%	49%	59%
2	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдтэй ажиллах, хамгаалах	31%	32%	21%	6%	5%	19%
3	Хүүхдийн хөгжлийн дэмжих уралдаан тэмцээн зохин байгуулах	32%	6%	18%	10%	46%	22%
	Дүн	100%	100%	100%	100%	100%	


2.2.2. Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалт нь ил тод тайлагнадаг эсэх?

Хүүхэд хамгаалалтай холбоотой шийдвэрүүдийг Шилэн дансны цахим сайтад байршуулан олон нийтэд мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар нь Шилэн дансны цахим сайтад 2019-2023 оны холбогдох 384 тушаал шийдвэрүүдийг байршуулан ажилласан.

График №2 Шилэн данс мэдээлэл



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитаар шалган зөвлөмж, албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тус газар нь 2019-2022 оны хүүхэд хамгааллын зардлын зарцуулалтын сарын мэдээг сар бүр, 2023 оны хүүхэд хамгааллын зардлын тайланг ХГБХХЕГ-т 2024 оны нэг дүгээр улиралд хүргүүлэн ажилласан байна.

2.2.3. Хүүхэд хамгааллын талаар Олон улсын донор байгууллагын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтын тогтолцоо бүрдсэн үү?

Нэмэлт санхүүжилтийн дансаар НҮБ-ын төсөл, хөтөлбөрөөр санхүүжсэн арга хэмжээг нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газарт 2019-2023 онд Нэгдсэн үндэсний байгууллагаас 310,979.9 мянга, НҮБ-ийн хүүхдийн сангаас 38,626,2 мянга нийт 349,606.1 мянган төгрөгийн хөтөлбөрүүд хэрэгжсэн байна.

Хүсгнэгт №11 Төсөл, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгийн судалгаа

ОУБайгууллагын нэр	2019	2020	2021	2022	2024	Нийт
НҮБ	23,363.0	93,186.6	21,382.5	71,589.1	25,000.0	234,521.2
Зуслангийн хөгжим					25,000.0	25,000.0
Сайн дурын ажилтан бэлдэх төсөл	21,375.0					21,375.0
Уур амьсгалын еерчлэлт, сургалтын зардал		6,833.0				6,833.0
Хамтарсан баг		36,953.6	17,360.5			54,314.1
Хамтдаа шийдье төсөл				71,589.1		71,589.1
Цахим оричинд нөлөөллий	1,988.0					1,988.0
Чип багц сайн дурын ажилтан бэлтгэх зардал			4,022.0			4,022.0
Хамтдаа шийдье		49,400.0				49,400.0
НҮБ Хүүхдийн ивээх сан	21,044.4		17,581.8			38,626.2
Хамтарсан баг	21,044.4		17,581.8			38,626.2
Нийт	44,407.4	93,186.6	38,964.3	71,589.1	25,000.0	273,147.4

Аудитын илрүүлэлт

НҮБ-аас 2020 онд “Хамтдаа шийдье” төсөлд гарын авлага хэвлүүлэхэд 49,400.0 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансаар орсныг ГБХЗХГ, Согоовор Арвай ХХК- тай “Хамтдаа шийдье” төслийн 16000 ширхэг гарын авлага хэвлүүлэхээр 47,500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 2020.11.20-ны өдөр төлбөрийг шилжүүлсэн. Тус төслийн хэрэгжилтийг шалгахад 2020 онд 5406 ширхэг гарын авлагыг хэвлүүлж айл өрхөд олгосон, 2021 онд 10594 ш хэвлүүлсэн.

2022 онд аймгийн ЗДТГ-аас 35,000.0 мянга, НҮБ-аас 36,589.1 мянга нийт 71,589.1 мянган төгрөгийн санхүүжилт авч аймаг сумдын айл, өрхөөр багийн дарга, сургуулийн нийгмийн ажилтан, сумын эрүүл мэндийн төвийн ажилтантай хамтран баг байгуулан бүх сумдын айл өрхөд танилцуулсан байна. Энэ нь 2020-2021 онд хэвлүүлсэн гарын авлага материалыг жилийн дараа танилцуулж тараасан нь төслийн хөрөнгийг үр нөлөөг бууруулж байна.

Олон улсын төсөл хөтөлбөрөөс санхүүжүүлсэн төслийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлагыг Баянхонгор аймгийн ХГБХХГ-ын даргад хүргүүлэв.

2.2.4. Хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ үзүүлж чадаж байна уу?

Баянхонгор аймгийн хэмжээнд асран хамгаалагчгүй бүтэн өнчин хүүхдэд хүүхэд асрах газар байхгүй харьяалал шилжүүлж асрамжид өгөх нөхцөл байдалтай байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дэх хэсэгт “Хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ” гэж заасан.

Баянхонгор аймгийн хүн амын статистик мэдээ




Баянхонгор аймгийн ХГБХХГ-ын хүүхэд хамгаалал, хөгжил оролцоог статистик мэдээнээс нэгтгэж харуулбал:

Хүснэгт №12 Статистик мэдээний нэгтгэл

Үйл ажиллагаа, арга хэмжээ	2019	2020	2021	2022	2023
Хууль ёсны төлөөлөгч	8/384ц	11/528ц	12/576	14/672ц	15/720ц
Хүүхдийн мэдүүлэгт оролцох	16/48ц	22/66ц	24/72ц	28/84ц	30/90ц
Шүүх хурал	3/15ц	4/20ц	5/25ц	8/40ц	9/45ц
Кейс уулзалт	8/32ц	10/40ц	13/52ц	13/52ц	15/60ц
Шинжээчийн дүгнэлт	6/42 хоног	4/28 хоног	7/49 хоног	6/42 хоног	3/21 хоног
Зөвлөгөө өгсөн иргэдийн тоо /Насанд хүрэгч/хүүхэд/	25 / 8	47 /17	132/31	120/27	81/22
Хүүхэд харах үйлчилгээ	0	0	6/30	9/45	9/45
ХБХ-ийн салбар комисс	9/164	20/280	21/315	19/355	20/249
Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн шалгасан хүүхдийн эрхийн зөрчил	3	4	1	7	4
Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зохион байгуулсан хяналт шалгалт	22	42	12	18	35+79
Хүүхдийн хөгжил, оролцооны чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ, хүүхдийн тоо	22/6478	10/602	10/578	12/3708	18/5206
Хүүхдийн нэгдсэн чуулган	220	150	150	250	260
Хүүхдийн оролцооны өөрөө удирдлагын байгууллага	113	118	124	150	161
Хүүхдийн элчийн чуулган	20	20	20	20	21

Аудитаар хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар 612 иргэнээс санал асуулгын дүнд нийт санал асуулгад оролцогчдын 50-аас дээш хувь нь Сайн болон маш сайн гэж хариулсан байна.

График №3 Иргэдээс авсан санал асуулга



Аймгийн хэмжээнд 2019-2023 онд 39-113 бүтэн өнчин хүүхэд байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийг аймаг, сумын Засаг даргын захирамжаар ойрын хамаатан садныг асран хамгаалагчаар нь тогтоосон байна. Эдгээр хүүхдүүд дээр хамтарсан багийн гишүүд хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд бүтэн өнчин асран хамгаалагч тогтоолгох ах дүү хамаатан садан байхгүй кэйс гарсан тохиолдолд хүүхдийг асрах газар байхгүй байгаагаас үзэхэд хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

2.2.5. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууц бүрэн хамгаалагддаг уу?

Хүүхэд хамгаалах чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагад хууц хамгаалах журам болон нууц хамриуцсан ажилтан байхгүй байгаагаас хувь хүний нууц задрах эрсдэлтэй байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А173, А/251, А380 тоот тушаалын хавсралаар батлагдсан “Хамтарсан багийн үйл ажиллагааг санхүүжүүлэх” журмын 6 дах заалтад нууцлал хангах тухай тусгасан байна.

Дээрх журмын дагуу “Нууцын гэрээ” -г аймгийн ХГБХХГ-ын мэргэжилтэн, хууль зүйн хорооны гишүүдтэй, сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн хүүхдийн эрхийг хамгаалах харилцаанд оролцож буй хамтарсан багийн гишүүнтэй байгуулж байгаа боловч зарим сумдын хамтарсан багийн гишүүд нууцын гэрээг бүрэн байгуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт

- Нэр бүхий сумын хамтарсан багийн гишүүд нууцын гэрээ байгуулсан эсэх нь тодорхойгүй, гишүүдийн хувийн хэрэг байхгүй,
- Зарим сумын нийгмийн бодлогын ажилтны нууцын баримт хадгалах (кэйс) шүүгээ нь цоожгүй.
- Хамтарсан багийн хурлын тэмдэглэл нь сумын ЗДТГ-ын ХХНЖ-т байнга хадгалагдах баримтын жагсаалтад орсноор сумын ЗДТГ-ын архивд бичиг хэргийн ажилтанд хадгалагдаж байна.
- Аймгийн ХГБХХГ-ын дарга нь хүүхдийн хууль ёсны төлөөлөгч, шинжээч томилохдоо эрсдэлд өртсөн хүүхдийн овог нэр, регистрийн дугаарыг тушаалд дурдсан, санхүүгийн анхан шатны баримтад хавсаргасан зэрэг зөрчлүүд байна.

Дээрх зөрчлүүд нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А173, А/251, А380 тоот тушаалын хавсралаар батлагдсан “Хамтарсан багийн үйл ажиллагааг санхүүжүүлэх” журам, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн 20.1.1 заалтыг зөрчиж байна.

Зөрчил арилгах албан шаардлагыг аймгийн ХГБХХГ-ын хүүхдийн эрхийн улсын байцагчид хүргүүлэв.

2.2.6. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв урьдчилсан сэргийлэх ажил болон хариу үйлчилгээнд оновчтой хуваарилагдан төсөвлөгдсөн байна уу?

Хүүхэд хамгааллын төсвийн төслийг урьдчилсан сэргийлэх ажил болон хариу үйлчилгээнд оновчтой хуваарилагдан төсөвлөхгүй байна.

Хүүхэд хамгааллын төсвийн төсөлд Хүүхэд хамгааллын тухай хуулийн заалтыг үндэслэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тусгасан боловч үндэслэсэн тоо хэмжээг тогтмолоор авсан, урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээг салгаж төлөвлөөгүй бөөн дүнгээр хүүхэд хамгааллын зардлыг тооцсон байна.

Хүснэгт№13 2019-2021 оны төсвийн төслийн хэсгээс

Хуулийн заалт	Төсөл арга хэмжээний нэр	Тоо хэмжээ 2019	Тоо хэмжээ 2021
Хүүхэд хамгааллын тухай хууль 5 дугаар зүйл	Хүмүүжлийн эерэг хандлага сургалт	2500	2500
Хүүхэд хамгааллын тухай хууль 6 дугаар зүйл	ЕБС. Цэцэрлэг хүмүүжлийн эерэг хандлага	1000	1000
Хүүхэд хамгааллын тухай хууль 8.9 дугаар зүйл	Хэвлэл мэдээлэл, цахим орчин хууль сурталчлах	500	500
Хүүхэд хамгааллын тухай хууль 15 дугаар зүйл	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдтэй ажиллах, хамгаалах	4388	4388
Хүүхэд хамгааллын тухай хууль 15 дугаар зүйл	Хамтарсан багийн санхүүжилт	29	29
Хүүхдийн эрхийн тухай хууль 6 дугаар зүйл	Хүүхдийн хөгжлийн дэмжих уралдаан тэмцээн зохион байгуулах	10000	

2022-2023 онд хүүхэд хамгааллын зардлыг бөөн дүнгээр төлөвлөж хөтөлбөр арга хэмжээгээр салгаж төлөвлөөгүй байна.

БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ ЭСЭХ?

ДҮГНЭЛТ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БОЛОВЧ КЕЙСИЙН ТОО БУУРАХГҮЙ БАЙНА.

3.1. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжиж буй үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо үр дүнтэй ажиллаж байна уу?

3.1. Хүүхдийн эрх хамгааллын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж байгаа боловч хяналтаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг тооцоогүй, хяналтын үр нөлөө бүрэн гаргаагүй байна.

3.1.1. Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх салбарын онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлалтай байна уу?

Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх салбарын онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал байхгүй байна.

ХГБХХГ нь 2019-2023 онд жил бүр хяналт шинжилгээ үнэлгээг хамтарсан багт хийж ирсэн бөгөөд хяналт үнэлгээ хийсэн шалгуур үзүүлэлтийг авч үзэхэд 2019, 2020 онуудад Хүүхэд хамгааллын тухай хуулийн үндэслэн хяналт шалгалтыг зохион байгуулсан бол 2021, 2022, 2023 онд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын баримтлан хийсэн байна.

Харин хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх салбарын онцлогт нийцсэн тусгай шалгуур үзүүлэлт бүхий аргачлал байхгүй байгаагаас үзэхэд ерөнхий байдлаар нийтлэг журмыг үндэслэл болгон хяналт шалгалтыг зохион байгуулж байна.

Иймд хүүхэд хамгааллын оролцогч талуудыг тогтсон аргачлалаар үнэлэх нь цаашид бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, ажлын үр нөлөөг сайжруулахад чухал ач холбогдолтой тул салбарын онцлогт нийцсэн тусгай шалгуур үзүүлэлт бүхий ажлын үр дүнг тодорхойлох аргачлал боловсруулах зөвлөмжийг ХГБХХЕГ-т хүргэх саналыг ҮАГ-ын ГНАГ-ын аудитын багт хүргүүлэв.

3.1.2. Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн талаар тогтмол судалгаа шинжилгээ, хяналт-үнэлгээ хийдэг байна уу?

Аймгийн хэмжээнд хүүхдийн чуулган зохион байгуулж хүүхдэд тулгамдсан асуудлыг тодорхойлуулж, эрэмбэлэн холбогдох төрийн байгууллагуудад уламжлан асуудлыг шийдвэрлүүлж байна.

Хүүхэд гэр бүл залуучуудын газар нь 2022 онд “Нэгдүгээрт хүүхэд уриан дор “Оролцоог эрхэмлэе- хөгжлийг түүчээлье” сэдвээр, 2023 онд “Оролцъё-хөгжье-хамгаалагдъя” сэдвээр хүүхдийн нэгдсэн чуулганыг 2 жил дараалан зохион байгуулсан байна.

Уг чуулганы зорилго нь Хүүхэд нийгмийн амьдралд оролцох эрхийг хэрэгжүүлэх, эвлэлдэн нэгдэх, хүүхдийн эрхийг хангах аливаа асуудлаар шийдвэр гаргахад оролцох, өөрсдийн санал бодлоо илэрхийлэх, нөхцөл боломжийг бүрдүүлэн тэдний хөгжлийг дэмжих гэж тодорхойлсон.

Дээрх арга хэмжээний гол онцлог нь хүүхдүүдэд тулгамдсан асуудлыг санал хэлбэрээр хүлээн авч эрэмбэлэн холбогдох хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд оролцдог байгууллагуудад уламжлан шийдвэрлэх чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон байна. Тус арга хэмжээний хүрээнд 2022 онд нийт оролцогч хүүхдүүдээс 34 санал гарч асуудлыг хэлэлцсэн бол 2023 онд 60 санал гарч чиглэл тус бүрээр асуудлыг ХГБХХГ-аас албан бичгээр хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт

Аймгийн хэмжээнд хүүхдийн нэгдсэн чуулганыг зохион байгуулж, тулгамдсан асуудлыг тодорхойлж, холбогдох төрийн байгууллагад асуудлыг хүргүүлсэн боловч асуудлыг шийдвэрлэсэн эсэх нь тодорхойгүй, биелэлттэй холбоотой нотлох барим байхгүй байна.

Иймд зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг гаргаж төрийн байгууллагуудад хүргүүлсэн саналын шийдвэрлэсэн байдлыг авч үр дүнг тооцох албан шаардлагыг ХГБХХГ-т хүргүүлэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны А/120 А/178 дугаар тушаалаар батлагдсан “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ын дагуу хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар болон хамтарсан баг нээсэн кейсд нөхцөл байдлын үнэлгээг хийж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын даргын хамтарсан 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Нээлттэй хяналт- шалгалт хийх тухай” А/34, А/12 тоот тушаал, удирдамжийн хүрээнд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтэд Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, сум багийн Засаг дарга, нийгмийн ажилтны бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт шалгалтыг хийж байна.

“Хүүхдэд ээлтэй орон нутаг” санаачилгын тогтвортой байдлыг хангах арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөнд нийт 12-15 ажил арга хэмжээг тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээрээс 2023 оны 11 сарын байдлаар зохион байгуулсан ажлууд: Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн хурлыг танхимаар 1 удаа зохион байгуулж 14 гишүүнийг хамруулсан. Сумдын Хүүхдийн төлөө зөвлөлийн 114 гишүүдийг 1-2 удаа арга зүйгээр ханган ажилласан. Хүүхэд хамгааллын бодлогыг байгууллагын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байгаа албан байгууллагын тоо боловсролын салбарт 121, бусад салбарт 42 байна. Аймгийн хэмжээний 115 төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдэд эцэг эхийн зөвлөл байгуулан ажиллах, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжийг өгч эргэн хяналт тавьж

ажилласан. Мөн 25 байгууллагад хүүхдийн эрхийн улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг авч ажилласан.

ХГБХХГ нь 20 сумын 29 хамтарсан багийн хяналт үнэлгээ 2019 оны үйл ажиллагаанд хийсэн бөгөөд тухайн үед ковид 19 цар тахлаас шалтгаалан сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа зогссон байсан тул хамгаалалт шаардлагатай өндөр эрсдэл бүхий 0-5 хүүхдүүдийг витаминжуулах, хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан 270 өрхөд дунд хугацааны үнэлгээ хийх хамтарсан багийн ажлыг үнэлэх ажлыг зохион байгуулсан байна.

Аймгийн хэмжээний 30 хамтарсан багийн нийгмийн ажилтны 12 нь /40%/ ганцаараа нэг өрөөнд суудаг ба хохирогчтой ганцаарчлан уулзах, сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх боломжтой байна. Түүнчлэн Баянхонгор сумын II, III, IX баг, Богд, Баянлиг, Баянговь, Эрдэнэцогт сумдад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан “Зөвлөгөө өгөх төв”, Хүрээмарал сумд “Хамтарсан багийн өрөө” байгуулан ажиллаж байна.

3.1.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон Улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж байна уу?

Баянхонгор аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт Олон Улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмжийн талаарх мэдээлэл байхгүй байна.

3.1.4. Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон улсын байгууллага, төрийн бус байгууллагаас хэрэгжүүлсэн, үйл ажиллагаа хөтөлбөрийн үр дүнг тооцож, нэгтгэж дүгнэдэг үү?

Хүүхэд хамгаалах чиглэлээр олон улсын байгууллага болон төрийн бус байгууллагаас хэрэгжсэн төслүүдийг нэгтгэж үр дүнг нэгтгээгүй байна.

Дэлхийн Зөн ОУБ Баянхонгор-2 хөтөлбөр нь 2019-2020 онуудад говийн зорилтот сумд болох Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Баянцагаан, Бөмбөгөр, Бууцагаан сумдад, Дэлхийн Зөн ОУБ Баянхонгор-1 хөтөлбөр нь 2019-2020 онуудад Баянхонгор, Эрдэнэцогт, Өлзийт сумдад хэрэгжсэн.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 34 дүгээр тогтоолоор “Хүүхдэд ээлтэй орон нутаг” дэд хөтөлбөр нь НҮБ-ын Хүүхдийн сангийн техникийн дэмжлэгтэйгээр 2018-2022 онуудад аймгийн хэмжээнд хэрэгжсэн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд нийт давхардсан тоогоор 87.000 иргэнд хүрсэн.

Аудитын илрүүлэлт

Аймгийн ХГБХХГ нь дээрх мэдээллээс өөр төсөл хөтөлбөр дүгнэсэн мэдээлэл ирүүлээгүй бөгөөд аймгийн хэмжээнд нийт хэдэн төсөл хэрэгжиж, үр дүнг нэгтгэсэн мэдээлэл дутмаг байна.

Иймд ОУБ-аас хэрэгжсэн төсөл, хөтөлбөр түүний үр дүнг нэгтгэж үр нөлөөг тооцож байх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэв.

3.1.5. Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээг бодитой хийж үнэн зөв тайлагнаж байна уу?

Хяналт шинжилгээ үнэлгээг дотоод болон хөндлөнгийн байдлаар хийж хэрэгжүүлсэн боловч үр дүнг тооцоогүй байна.

Хүүхэд хамгаалалтай холбоотой бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс үнэлж тайлагнасан бол хамтарсан багийн хэрэгжилтийн тайланд ХГБХХГ-ын мэргэжилтэн хяналтыг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

ХГБХХГ нь 2022 оны үйл ажиллагааны иж бүрэн хяналт-шинжилгээ үнэлгээг Төрийн байгууллагын зохион байгуулалт, байгууллагын үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлт, архив, Архив албан хэргийн хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлсэн байдал, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, дотоод хяналтын үйл ажиллагаа гэсэн 7 үзүүлэлтээр үнэлж нийт 6470 оноо авахаас 5867 буюу 91.14 хувьтай үнэлсэн бол 2023 онд 8 чиглэлээр үнэлж 98.4 хувиар үнэлсэн байна.

Дээрх хяналт үнэлгээнд байгууллагын хэмжээнд хэрэгжсэн хөтөлбөр арга хэмжээний сайн талыг дурдсан бол дутагдалтай болон анхаарах асуудлыг гарган зөвлөмж гаргасан сайн талтай байна.

Мөн анхаарвал зохих асуудалд 2022 онд 12, 2023 онд 18 төрлийн зөвлөмж өгснөөс хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой дараах зөвлөмжүүдийг өгсөн байна.

- ✓ Гэр бүл хүүхэд залуучуудын чиглэлээр үйл явуулдаг төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах
- ✓ Хүүхдэд зориулж контент бэлтгэх, нэвтрүүлгийн цагтай болох
- ✓ Эрсдэл өндөр хүүхдийн судалгааг шинэчлэн гаргаж, шаардлагатай үйлчилгээг үзүүлэх
- ✓ Хараа хяналтгүй хүүхэдтэй ажиллах
- ✓ Бичил уурхай эрхлэгчдийн хүүхдүүдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах гэх мэт

Аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022, 2023 оны бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 2023 онд 70.4 хувь, 2023 онд 76.6 хувиар үнэлж зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

- ✓ Залуучуудын сэтгэл зүй, хөгжил эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжсэн хөтөлбөрт арга хэмжээ хэрэгжүүлэх
- ✓ Сум бүрд хөдөлмөр зуслан байгуулж, хүүхдийг Монгол ахуйд сургах
- ✓ Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээх
- ✓ Охилын төрөлтийг тэглэх нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- ✓ Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэргийн тоог бууруулах нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэх мэт

Аудитын илрүүлэлт

Дээрх хяналт хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ-ын ХШҮ хэлтэс болон ХГБХХГ-ын дотоод хяналт үнэлгээний мэргэжилтэн нь өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцоогүй байна.

Иймд цаашид дотоод хяналтаар илрүүлсэн зөрчилтэй асуудлын засаж сайжруулахад чиглэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаж үр дүнг тооцож ирүүлэх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтэс болон аймгийн ХГБХХГ-ын дарга нарт хүргүүлэв.

3.1.6. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал байна уу?

Аймгийн ХГБХХГ нь хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх “Шалгах хуудас”-ыг бий болгон орон нутгийн түвшинд ажлын үр дүнг үнэлж байна.

Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/110 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар”-ыг баталсан бөгөөд Баянхонгор аймагт бодлогын баримт бичгийг 156 байгууллагад мөрдүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Аймгийн ХГБХХГ нь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын болон бусад төрийн байгууллагуудад хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг шалгах хуудсыг 0-5 оноогоор үнэлэх “Шалгах” хуудас”-ыг 3 ангиллаар гаргасан байна.Үүнд

1. Ерөнхий боловсролын сургуулийн “хүүхэд хамгааллын баг”-ийн үйл ажиллагааг шалгах хуудас
2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын “хүүхэд хамгааллын баг”-ийн үйл ажиллагааг шалгах хуудас
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг шалгах хуудас

Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх бодлогын хэрэгжилт үр дүнг үнэлэх тусгайлсан аргачлал байхгүй ч гэсэн аймгийн ХГБХХГ нь шалгах хуудас гаргаж үр дүнг тооцож байгаа нь сайн талтай байна.

3.1.7. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлж нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлж байна уу?

Баянхонгор аймгийн хүүхдүүд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин сайжирснаар спортоор хичээллэх сонирхол нэмэгдэх эерэг хандлагатай байна.

Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлж ажиллаж байгаа бөгөөд сүүлийн жилд кейсийн тоо нэмэгдэж байгаа нь хэдий сөрөг үзүүлэлт боловч далд хэлбэрээр үйлдэж байсан хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүчирхийллийг ил болгон асуудлыг тухай бүр нь шийдэж байгаа эерэг тал ажиглагдаж байна.

Мөн байгууллага бүрд хүүхэд хамгааллын баг бий болж Хүүхдийн чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллаж эхэлсэн нь чухал ач холбогдолтой байна.

Сүүлийн жилүүдэд Баянхонгор аймагт Соёл, амралтын хүрээлэн болон багийн спорт зал шинээр нэмэгдсэн нь ард иргэдийн эрүүл идэвхтэй амьдрах, хүүхэд багачуудын спортоор хичээллэх сонирхол нэмэгдэж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл боломж бүрдсэн байна.

Хүүхэд залуучууд спорт нийтийн биеийн тамираар хичээллэх байдал нэмэгдсэний үр дүнд Баянхонгор аймгийн төвд РС тоглоомын газрын тоо буурсан үзүүлэлттэй байна.

Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн ААН-үүдийн хөрөнгө оруулалтаар нийтийн эзэмшлийн талбайн бүтээн байгуулалтууд хийсэн нь орон нутагт үр ашгаа өгч байна. Тухайлбал:

Оготнотой булгийн тоглоомын талбай цогцолборын хөрөнгө оруулалтыг уул уурхайн аж ахуй нэгжүүд болон бусад эх үүсвэрээс шийдвэрлэсэн байна. Үүнд:

- ❖ Волейболын талбай
- ❖ Сагсан бөмбөгийн талбай
- ❖ Хүүхдийн тоглоомын талбай
- ❖ Мөсөн талбай
- ❖ Крикитийн талбай
- ❖ Дугуйн зам
- ❖ Авто зогсоол

Оготнотой булгийг түшиглэсэн соёл, амралтын хүрээлэн



3.2. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ нь үр нөлөөтэй байна уу?

3.2. Хүүхэд хамгааллын талаар холбогдох төрийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ нь үр нөлөөгөө өгсөн байна.



3.2.1. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт гэр бүлийн орчинд нөлөөлж чадаж байна уу?

Бодлогын хэрэгжилтийн үр дүнд гэр бүлийн орчинд үйлдэх гэр бүлийн зөрчлийн тоо буурч байна.

Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газар нь “Хамтдаа шийдье” төсөл хэрэгжүүлсэн байна. Энэ төслийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл бууруулах, илрүүлэх, залуу гэр бүлүүдэд гэр бүлийн боловсрол олгох, бага насны хүүхдийн цогц хөгжил хөтөлбөрийг эцэг эхчүүдэд зорилгын хүрээнд 10,623 өрхөд сургалт зохион байгуулсан арга хэмжээ болсон байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн зөрчил 2022 онд 250 байсан бол 2023 онд 206 болж 17.6%-иар, Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 30,8%-р тус тус буурсан байна.

График №4 Ахлах ангийн сурагчдаас авсан судалгаа



Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага мэдээллийн судалгаагаар нийт ирсэн дуудлагын 45,4 хувь гэр бүлийн орчноос ирсэн дуудлага эзэлж байгаа нь гэр бүлийн орчинд хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт хангалттай биш байна.

Хүснэгт №14 108 утасны дуудлагын ангилал

Дуудлага мэдээллийн төрөл	Хүүхэд хамгааллын үйлчилгээний тоо	Эзлэх хувь
Гэр бүл дэх хүүхэд хамгаалал	239	45,4%
Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал	230	43,7%
Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал	57	10,8%

3.2.2. БОЛОВСРОЛЫН САЛБАР ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ БАРИМТЛАН АЖИЛЛАЖ ЧАДАЖ БАЙНА УУ?

Боловсролын салбарт хүүхэд хамгааллын бодлого хэрэгжиж байгаа боловч аймгийн Боловсролын газар нь журамд заасны дагуу хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд 32 ерөнхий боловсролын сургуульд хүүхэд хамгааллын багаар дамжуулан 18,550 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлж байна.

Баянхонгор аймгийн Боловсролын газраас 2022-2023 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалал үйлчилгээний жилийн тайланг үнэлж гаргасан байна.

Боловсролын байгууллагаас сургуулийн хэмжээнд нийт суралцагчийн эрсдэлийн үнэлгээ хийхэд өндөр эрсдэлтэй 977 хүүхэд байгаа нь нийт суралцагчийн 5,2% ийг эзэлж байна.

Хүснэгт №15 Эрсдлийн үнэлгээний тайлан

Үзүүлэлт			Бүгд
ЕБС-ийн хүүхэд хамгааллын бодлогыг дагаж мөрддөг сургууль			32
Сургуулийн хүүхэд хамгааллын багийн гишүүд			273
Сургуулийн хэмжээнд нийт суралцагчийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал	Тухайн хичээлийн жилд эрсдлийн үнэлгээнд оролцсон нийт суралцагч		18520
		Огт эрсдэлгүй	5971
		Бага эрсдэлтэй	8774
		Дунд эрсдэлтэй	2798
		Өндөр эрсдэлтэй	977
Сургуулийн хүүхэд хамгааллын баг, нийгмийн ажилтан, захиралд ирсэн хүүхдийн эсрэг хүчирхийллийн дуудлага мэдээлэл			225
	Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж тогтоогдоогүй дуудлага, мэдээллийн		133
	Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж тогтоогдсон дуудлага мэдээллийн		92
Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр тус бүрээр тогтоож бүртгэгдсэн тохиолдлын	Бие махбодийн хүчирхийллийн тохиолдлын	Гэр бүлийн зүгээс	30
		Багш, ажилтны зүгээс	7
		Бусад	32
	Сэтгэл санааны хүчирхийллийн тохиолдлын	Гэр бүлийн зүгээс	34
		Багш, ажилтны зүгээс	8
		Бусад	61
	Үл хайхрах хүчирхийллийн тохиолдлын	Гэр бүлийн зүгээс	112
		Багш, ажилтны зүгээс	
		Бусад	19
	Бэлгийн хүчирхийллийн тохиолдлын	Гэр бүлийн зүгээс	1
		Багш, ажилтны зүгээс	
		Бусад	3
Үе тэнгийн дээрэлхэлтийн тохиолдлын	Бие махбодын		134
	Сэтгэл санааны		171
	Харилцааны		337
	Цахим		67
	Бусад		32

Боловсрол, соёл, шинэлэх ухаан, спортын сайдын журам батлах тухай 2018 оны А/239 дугаар тушаалаар Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журмыг мөрдөж байна.

Аудитаар Галуут, Богд, Шинэжинст, Баян-Өндөр, Баян-Овоо сумын сумын сургууль, цэцэрлэг, Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор, Эрдэм ахлах сургууль, 10 дугаар цэцэрлэг, 13-р цэцэрлэгүүдийг түүвэрт хамруулахад хүүхэд хамгааллын баг ажиллаж байгаа нь дээрх журмыг хэрэгжүүлж ажилласан байна.

Гараас гарт, камер ашиглах, дотуур байранд гаднын хүн нэвтрэх журам, хүүхэд хамгааллын бодлого, дүрэм зэрэг бичиг баримтуудыг боловсруулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 28 дотуур байранд 1793 сурагч амьдарч байна.

Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн хүрээнд НҮБ-ын хүүхдийн сантай хамтран сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн өрөөнүүдийн засвар, зөөврийн ариун цэврийн байгууламж, сайжруулсан 00, дулаан алдагдал бууруулах, нарны эх үүсвэртэй гэрэлтүүлэг зэрэг нийт 1,440.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж ээлтэй орчин бүрдүүлсэн байна.

Кэйс: дотуур байранд амьдарч байсан хүүхэд оройн цагаар гадаа 00 орох гэж гараад хуучирсан нүхэн жорлон, гэрэлтүүлэг байгүй нөхцөл байдлаас болж муу усны нүх цөмөр амь насаа алдсан хэрэг гарч байсан орчны шаардлага хангаагүй асуудал дээрх төслөөр шийдэгдсэн байна.

Хүүхэд хамгааллын багийн сайн жишээ:

Богд сумын ерөнхий боловсролын сургууль хүүхэд хамгааллын зөвлөгөө, өгөх зөвлөн туслах, эрсдэл нөхцөлт байгаа хүүхдийг илрүүлэх зорилгын хүрээнд 2022 оноос “Багш айлчлал хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн байна.

Хөтөлбөрийн үр дүнд 264 хүүхдийн ахуй орчинтой танилцаж зөвлөн тусалсан байна. Мөн 17 асуумжаар судалгааг 264 хүүхдээс авч эрсдэл өндөр 8 хүүхдийг илрүүлэн дотуур байранд авсан байна.

Хараа хяналт сул 103 сурагчийн судалгааг гаргаж зөвлөн туслах, эрүүлийн хуваарьт оруулан 19-23 цагийн хооронд хуваарийн дагуу эргүүл хийж хүүхдүүдийг аливаа эрсдэл, гэнэтийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллажээ.

Аудитын илрүүлэлт

Аймгийн Боловсролын газар нь дээрх журмын хэрэгжилтийн тайланд хяналт тавьж үнэлгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлээгүй, сайн жишээг бусад сургуулиудад түгээх ажлыг зохион байгуулаагүй нь Боловсрол, соёл, шинэлэх ухаан, спортын сайдын журам батлах тухай 2018 оны А/239 дугаар тушаалаар Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журмын 6.2 , 6.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.


Иймд Богд сумын сургууль хүүхэд хамгааллын зөвлөгөө, өгөх зөвлөн туслах, эрсдэл нөхцөлт байгаа хүүхдийг илрүүлэх зорилгын хүрээнд “Багш айлчлал хөтөлбөр”-ийн сайн жишээг аймгийн хэмжээнд бусад сургуульд түгээн дэлгэрүүлэх зөвлөмжийг аймгийн Боловсролын газарт хүргүүлэв.

Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2022 оны А/214 дугаар тушаалаар -ЕБС, Дотуур байрны орчинд сурагчийг үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааны чиглэл”-ийг баталсан байна.


Аудитаар Баянхонгор аймгийн ЕБС-ийн ахлах болон дунд ангийн 907 хүүхдээс 5 асуулгын хүрээнд судалгааг авч үр дүнг нэгтгэхэд дараах үр дүн гарч байна.

График №5 Ахлах ангийн сурагчдаас авсан судалгаа

1. Хүүхдийн тусламжийн 108 утсыг мэдэх үү?
899 responses




2. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагыг мэдэх үү ?
897 responses




3. Үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтад өртөж байсан уу ?

896 responses




4. Танай сургуулийн нийгмийн ажилтан хүүхдийн эрхийн талаар сургалт, зөвлөгөө өгдөг үү ?

889 responses



5. Цахим гадуурхалтад өртөж байсан уу ?

895 responses



Дээрх байдлаас үзэхэд хүүхэд хамгааллын үйлчилгээг 25 мэдэхгүй, үе тэнгийн дээрхлэлт, ялгаварлан гадуурхалт 24.3 хувь, нийгмийн ажилтан сургалт өгдөггүй 25 хувь цахим гадуурхалт 13.6 хувь байгаа сөрөг үзүүлэлт гарч байна.

3.2.3. Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал хангагдаж байна уу?


Аймгийн Эрүүл мэндийн газар нь хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт нөлөөллийн ажлыг хийж үр дүнг тооцож ажилласан байна.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Хүүхдийн эсэн мэнд амьдрахуй, хөгжил” хөтөлбөрийг 2017-2021 онд дараах зорилтын хүрээнд 85.7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

- Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах
- Өсвөр үеийнхний эрүүл мэндийг сайжруулах
- Бэлгийн замаар дамжих халдварт өвчний тархалтыг бууруулах
- Эх хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах
- Орчны эрүүл мэндийг сайжруулах

Баянхонгор аймгийн хэмжээнд эх, хүүхдийн эндэгдэл сүүлийн 5 жилд 18,8,-3,3% болж буурсан байна.

Дүрслэл№6 Хүүхдийн эндэгдлийн өсөлт бууралт




Бэлгийн замаар дамжих халдварт өвчний тархалтыг бууруулах зорилгын хүрээнд 2020, 2021 онуудад Баянхонгор сумын ЕБС-ийн 09-12 ангийн 1200 орчим хүүхдийг

хамруулан сургалтыг зохион байгуулж БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх, өсвөр насны жирэмслэлтээс сэргийлэх зөвлөгөө өгсөн байна.

Оролцогчдын мэдлэгийг сориход сургалтын өмнөх мэдлэг 48.6 хувь байсан бол, сургалтын дараах мэдлэгийн түвшин 76.9 хувь болж 28.3 хувиар өссөн байна.

Баянхонгор аймгийн эрүүл мэндийн судалгаагаар 2019-2023 оны хугацаанд БЗХӨ, эрт жирэмслэлт, үр хөндөлтийн тоо буурсан үзүүлэлттэй байна.

Дүрслэл№7 Нөхөн үржихүйн судалгаа



Тус газар нь хүүхдийн бэлгийн хүчирхийллийг бууруулах, илрүүлэхэд Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн үр хөндөлт, эрт жирэмслэлтийг аймгийн Цагдаагийн газар мэдээлж хамтран ажилласан байна.

Аймгийн Эрүүл мэндийн газраас 2023 онд Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/370 дугаар тушаалаар баталсан “Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт”-аар сургууль орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнд хяналт шалгалтыг хийж, хяналт шалгалтаар 15 үйлчилгээний байгууллагад хяналт шалгалт хийж 6 газарт албан шаардлага өгч хэрэгжилтийг хангуулсан боловч зөрчил арилахгүй байна.

ХГБХХГ-аас 2023 онд “Хүүхдэд ээлтэй бизнесийн зарчим”, “Хүүхэд эрхэм хэрэглэгч” нөлөөллийн ажлыг зохион байгуулж 512 эцэг эхчүүдэд хориглосон хүнсний бүтээгдэхүүний хор хөнөөлийн талаар сургалтыг зохион байгуулсан байна

Мөн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид электрон тамхи хэрэглэж байгаа нөхцөл байдал ихэссэн байна.

Иймд сургуулийн орчинд худалдаалж буй хүнсний хэрэглээ болон электрон тамхины хэрэглээг хязгаарлах асуудлыг шийдвэр гаргагч нарын түвшинд асуудлыг тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг ХГБХХГ-ын даргад хүргүүлэв.

3.2.4. *Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал хангагдаж байна уу?*

Цахим орчинд хүүхэд эрсдэлд өртөж болзошгүй байдлыг хянаж боломжгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дэх хэсэгт “Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана” гэж заасан байна.

Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаг Номгон, Баянхонгор гэсэн 2 телевизтэй байгаа бөгөөд ХГБХХГ нь Номгон телевизтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд эерэг нөлөө үзүүлэхүйц мэдээ мэдээлэл, зар сурталчилгааг олон нийтэд Монгол-Сат 810-р суваг, Юнивишны 942-р суваг, Баянхонгор Номгон телевизийн пэйж хуудсаар дамжуулан 2019-2023 оны хугацаанд 38 удаагийн хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлийн нэвтрүүлэг, контентыг хүргэсэн байна.

Харилцаа холбооны зохицуулах зөвлөлийн төлөөлөгч Баянхонгор аймаг байдаггүй үйл ажиллагаа явуулж байгаа телевизүүдэд хүүхдэд зориулсан мэдээ, мэдээлэл, хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй, хүүхдийн насны ангилал зөрчсөн ямар нэгэн зөрчил түүнтэй холбоотой хяналт үнэлгээ хийгээгүй байна.

Бага ангийн хүүхдүүдийн зарим нэг сургалтын материалыг Facebook групп үүсгэж боловсролын байгууллагаас сургалт хөгжлийн үйл ажиллагаа явуулж байгаа нь бага насны хүүхдүүд цахим халдлагад өртөх эрсдэлийг эцэг эхчүүд өөрсдөө бий болгож байна.

Иймд цахим гэмт хэргийг хязгаарлах хөтөлбөрийг аймгийн хэмжээнд бодлого боловсруулан батлуулж, хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг ХГБХХГ-ын даргад хүргүүлэв.

3.2.5. *Олон нийтийн арга хэмжээ, Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхэд хамгаалал хангагдаж байна уу?*

Аймгийн ХГБХХГ Олон нийтийн арга хэмжээ, Соёл, спортын үйл ажиллагаанд зөвлөмж хүргүүлэн хүргүүлэн хүүхэд хамгааллын арга хэмжээг авч ажилласан.

Соёл урлагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга нарын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/242, А/76 хамтарсан тушаалаар баталсан “Соёл, спорт олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ын хэрэгжилтийг ханган, хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллах ажлын хүрээнд Хүүхдийн эрхийн улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг

аймгийн Хөгжимт драмын театр, БТСГазар, Боловсролын газар, ЕБС-иудад хүргүүлсэн.

Журмыг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг аймгийн БТСГазрын 40 албан хаагч болон нийт 81 хөгжлийн хөтөлбөр хариуцсан багш нарт зохион байгуулсан байна.

Боловсролын байгууллага аймаг орон нутгийн бүх төрлийн тэмцээн, уралдаанд оролцож байгаа хүүхдүүдийг эцэг эх асран хамгаалагчийн зөвшөөрөл авч сургууль, дасгалжуулагч, сурагчид хоорондын хамтарсан гэрээг байгуулж журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Баянхонгор аймагт 2023 онд Хүүхдийн спортын зуны наадам зохион байгуулагдаж 5227 хүүхэд оролцсон байна. Энэ арга хэмжээний үеэр ХГБХХГ нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.4 дах заалт, “Соёл, спорт олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ын 2.2-д заасан заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна

3.2.6. Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал хангагдаж байна уу?

Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөнд хүүхдэд ээлтэй өвөлжилтийн төлөвлөгөөг тусгайлан боловсруулж , хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны А/89 дүгээр тушаалаар Гамшгийн үеийн болон өвөлжилтийн бэлэн байдлыг хангах орон нутгийн бодлого, төлөвлөлтийн хүүхдэд ээлтэй байдлыг хангах ажлыг хэсгийг томилсон байна.

Аймгийн гамшиг, өвөлжилтийн төлөвлөлтөд НҮБ-ын хүүхдийн сангаас боловсруулсан “Хүүхдэд ээлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах, өвөлжилтийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөө боловсруулах заавар”, Гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS 6948:2021-ийн хүрээнд үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлж чадавхжуулсан байна. Мөн аймгийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөнд Хүүхдэд ээлтэй өвөлжилтийн төлөвлөгөөг тусгайлан боловсруулан аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтөд 11 ажил арга хэмжээ авахаар тодотгол хийсэн байна.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь Хүүхэд хамгааллын тухай хууль, Засгийн газрын 2015 оны 303-р тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр” , “Гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын MNS 6948: стандартын хүрээнд жил бүр бага насны хүүхдийг гамшиг, аюулт үзэгдэл, гал түймэр, ахуйн осол гэмтлээс сэргийлэх сургалт нөлөөллийн арга хэмжээн өссөн тоогоор 22500 хүүхдийг хамруулсан байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 2019-2023 оны хугацаанд объектын гал түймэрт 2, зам тээврийн ослоор 2, усны ослоор 1, нийт 5 хүүхэд амь насаа алдаж 8 хүүхэд хүнд бэртэж гэмтсэн байна.

3.3. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үр дүнтэй байж чадаж байна уу?

3.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр холбогдох төрийн байгууллагууд зохих арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч кейсийн тоо буурахгүй, хүүхдийн эрхийн зөрчил гарсаар байна.

3.3.1. Монгол Улс Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод нэгдсэн үүргийг хангалттай хэрэгжүүлдэг үү?

Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод туссан үүргийг зохих түвшинд хэрэгжүүлэн ажилласан байна.

Баянхонгор аймаг нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийн 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 онд 46 үзүүлэлтээс орон нутагт хамааралтай 15 үзүүлэлтээр гаргаж хүргүүлсний дотор хүүхэд хамгаалах чиглэлээр дараах хэрэгжилтийг гаргасан байна. Үүнд:

➤ **Хууль тогтоомжийн хүрээнд**

Хүүдэд ээлтэй орчин бүрдүүлэх, шийдвэр гаргагчдын ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, салбар дундын уялдааг хангах зорилгоор Аймгийн ИТХ-ын шийдвэрүүд гаргуулан “Хүүхэд хамгааллын жишиг бодлогын баримт бичиг”-ийг үр дүнтэй хэрэгжүүлж буй байгууллагын тоог 192-т хүрсэн байна.

➤ **Хүүхдийн эрхийг хангах**

а) “Хүүхдэд ээлтэй орон нутаг” дэд хөтөлбөрийг 2017-2022 онд хэрэгжүүлж, хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэнд, боловсрол, хүүхэд хамгааллын салбарт хэрэгжүүлж, хүүхдийн өмнө үүрэг хариуцлага хүлээгчдийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан.

б) Аймгийн Засаг даргын захирамжаар сар бүрийн эхний 7 хоногийн дүрэм гарагийг “Хүүхдээ сонсох өдөр болгон зарлуулж

с) Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбар Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулсан.

АНХААРАЛ ТАТАХУЙЦ АСУУДАЛ

➤ **Хүүхдийн эрхийг хангах**

Хүүхдийн тусламжийн 108 утсанд бие махбодын шийтгэлд өртсөн тухай дуудлага 2018 онд 83 кейс, 2019 онд 85 кейс, 2020 онд 103 зейс бүртгэгдсэн ба гэр бүлийн орчинд бие махбодын шийтгэлд өртөх асуудал 69 хувийг эзэлж байна.

➤ **Иргэний эрх чөлөө**

Хүүхдийн амиа хорлолт сүүлийн 2 жилд 2 тохиолдол бүртгэгдсэн .

3.3.2. 108 утсанд ирсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн мөрөөр шаардлагатай арга хэмжээ авдаг уу?

Хүүхдийн 108 утсанд дуудлага мэдээлэлд дүн шинжилгээ хийж шийдвэрлэж байгаа бөгөөд 2019-2023 оны хугацаанд дуудлага кейсийн шийдвэрлэлт дунджаар 91.8 хувьтай байна.

Баянхонгор аймгийн ХГБХХГ нь 2019-2023 оны хугацаанд хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс зорилтод дуудлага 493, зорилтод бус зөвлөгөө хүссэн дуудлага 94 нийт 587 дуудлага хүлээн авч хүүхэд хамгааллын холбон зуучлах үйлчилгээг үзүүлсэн байна.

Хүүхдийн тусламжийн 108 -ын дуудлага ирсэн даруйд ХГБХХГ нь дуудлага тус бүр дээр нөхцөл байдлыг үнэлгээ хийж эрсдэл өндөр (бэлгийн хүчирхийлэл) кэйсийн ХГБХХГ дээр кэйс нээж хамгааллын үйлчилгээг үзүүлдэг бол бусад дуудлагыг хамаарах сум, багийн хамтарсан багт шилжүүлэн кэйс нээн ажилласан байна. 2019-2023 оны хугацаанд кэйс шийдвэрлэлтийн дундаж хувь 91,8% байна.

Он дамнаж хаагдаагүй кэйсийн шалтгаан нөхцөл байдал нь бэлгийн хүчирхийллийн кэйс шүүхээр шийдэгдэхгүй удах, хуурамч дуудлага бүртгэгдэх, хамтарсан багийн хариуцаж байсан ажилтан кэйсээ хаалгүй ажлаас гарах зэргээс шалтгаалжээ.

Хүснэгт№16 Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн дуудлага

	Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Нийт дуудлага	82	102	146	148	109
2	Зорилтот дуудлага	57	87	128	119	102
3	Зорилтот бус дуудлага	25	15	18	29	7
4	Хүүхэд хамгааллын кейсийн тоо, кейс шийдвэрлэлтийн хувь	49 (85,9%)	80 (91,9%)	115 (89,8%)	116 (97,4%)	96 (94,1%)
5	Он дамнаж ажиллаж байгаа кейсийн тоо	8	7	13	3	6


3.3.3. Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээ стандартад нийцсэн, түргэн шуурхай байна уу?

Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдийн кейсийг зарим сумын хамтарсан багийн гишүүдийн ажлын хариуцлагагүй байдлаас шалтгаалан стандартын дагуу шуурхай арга хэмжээ авч чадаагүй байна.

Хамтарсан багийн нийгмийн ажилтнууд өөрийн харьяа сум, багийн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг авч ХГБХХГ хүргүүлж тус газар нь эрсдэлт судалгааг нэгтгэж он оноор сан мэдээллийн бүрдүүлсэн байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын үйлчилгээг анхан шатны нэгж дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа 29 хамтарсан баг ажиллаж байгаа бөгөөд бүрэлдэхүүнд хуулиар тодорхойлсон албан тушаалтнуудыг томилсон байна.

График№8 Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгаа



Хамтарсан багаар дамжуулан 2019-2023 онд нийт 8286 хүүхэд хүүхэд хамгааллын үйлчилгээ авч кэйс шийдвэрлэлт 87% тай байна.

Аудитаар хаагдсан 239 кэйсээс түүвэрлэн 21 кэйс буюу 9 хувийг хамруулан шалгахад кэйс менежментийг үе шатны дарааллын дагуу хийгдсэн байна.

2021 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хамтарсан багийн үйлчилгээний мэдээллийн санг цахимжуулж, namc.gov.mn программыг хөгжүүлсэн боловч бодит байдал дээрээ Баянхонгор аймгийн хэмжээнд хэрэгжээгүй, ашиглалт байхгүй систем доголдолтой байгаагаас үзэхэд системийн үр дүнг гараагүй байна.

Хүснэгт 17. Хамтарсан багаас хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоо

Үзүүлэлт	2020	2021	2022	2023
Хамтарсан багийн тоо	29	29	29	30
Гишүүдийн тоо	353	378	373	373
Үйлчилгээ авсан хүүхдийн тоо	5,895	6,145	8,869	9,845
Кэйс шийдвэрлэлтийн хувь	75	70	70,5	87

ХГБХХГ-аас 2023 онд хамтарсан багт хийсэн хяналт хийхэд зорилт, арга хэмжээг оновчтой тодорхойлсон шалгуур, үзүүлэлт зорилтод түвшиндээ хүрсэн 18, үр дүн гарч эхэлж байгаа 9, үйл ажиллагаа нь хангалтгүй 3 хамтарсан баг байжээ.

2019 оны ХГБЗХГ, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран хийсэн хяналт үнэлгээгээр хамтарсан багийн гишүүдэд өгсөн үнэлгээнд тухайн ажлын байранд шаардлага хангасан мэргэжил эзэмшсэн гишүүдийн эзлэх хувь 24,3%, иргэд олон нийтэд чиглэсэн ажилд оролцсон гишүүдийн хувь 56%, хамтарсан багийн хуралд оролцон гишүүдийн ирц 53,6% байсан байна.

Хамтарсан багийн гишүүдийн үүрэг оролцоо хангалтгүй байгааг суманд гарсан кэйс харуулж байна.

Нэгэн сумын 8 настай хагас өнчин хараа хяналтгүй эмэгтэй хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн байхад сумын хамтарсан багийн гишүүн эрүүл мэндийн мэндийн төвийн дарга, сургуулийн нийгмийн ажилтан, сургуулийн хүүхэд хамгааллын багийн гишүүн, сумын нийгмийн бодлогын ажилтан, сумын Засаг дарга үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Уг хүүхэд хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртөж БЗХӨ тусч эрүүл мэндийн үйлчилгээ авахад сумын эмч илрүүлж онош гаргаж чадаагүй буцаасан, хүүхдийн нөхцөл байдал тухайн үед биед нь зодуулсан шархтай, хувцас хунар муутай, хичээлийн хоцрогдолтой байсныг сургуулийн нийгмийн ажилтан, анги удирдсан багш анхан шатны арга хэмжээ авч хамтарсан багт мэдээлээгүй. Хамтарсан багийн ахлагч, нийгмийн ажилтан эрсдэлт нөхцөл байгаа хараа хяналтгүй хүүхдүүдийн судалгаанд багтсан хүүхдүүдээ эргэх холбоо тогтоож хяналтаа хэрэгжүүлээгүй байна. Мөн тухайн хүүхдийн нууц тус суманд задарсан тухай Хүүхдийн эрхийн улсын байцаагч тус суманд ажиллахаа мэдсэн байна.

Харин ХГБХХГ хүүхэд хамгаалах хариу үйлчилгээг түргэн шуурхай авч хэрэгжүүлж ажиллаж эрүүл мэндийн үйлчилгээ болон сэтгэл санааны нөхөн сэргээх эмчилгээ хийсэн байна. ХГБХХГ-ын Хүүхдийн эрхийн улсын байцаагч зөрлийн хэрэг нээж Зөрчлийн тухай хуулийн 6.20.8 дахь заалтын дагуу сумын эрүүл мэндийн төвийн дарга, нийгмийн бодлогын мэргэжилтэн, анги удирдсан багш, сургуулийн нийгмийн ажилтан зэрэг 4 хүнийг 300 нэгжээр улсын байцаагийн эрхийн хүрээнд торгосон байна. Цагдаагийн газар эрүүгийн хэрэг үүсгэн шалгалтын ажиллагаа хийсэн.

Иймд цаашид хамтарсан багийг чадавхжуулж, хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажиллах арга зүйгээр хангах, эрсдэлт нөхцөл байдлын зөрчлийг давтан гаргахгүй байх, албан тушаалтнуудтай байгуулах үр дүнгийн гэрээнд хүүхэд хамгааллын талаарх заалтыг тусгах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Үндэсний морин уралдааны уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS6264:2018 стандарт, ЗГ-ын 2019 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж, хяналт ХГБХХГ-аа ХЭУБ-ийн зөвлөмжийг сумдын ЗДТГ-т жил бүр хүргүүлж ажилласан.

Аймгийн хэмжээнд 2019-2023 172 удаагийн хурдан морины уралдаанд 4811 уралдаанч хүүхэд бүртгэгдэж 100% гэнэтийн ослын даатгалд даатгуулсан байна.

3.3.4. Хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч чадаж байна уу?

Аймгийн Цагдаагийн газар болон, ГХУСАЗСЗ, ХЭХЗХ нь хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2017 оны А/719 тоот захирамжаар Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулж 2022 оны А/56 тоот захирамжаар бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан байна.

ХЭХЗХ-ны даргаар аймгийн ЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтсийн даргыг томилсон ба урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, гэмт хэрэгт холбогдсон, гэрч хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 2020-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 67 ажил төлөвлөж хэрэгжүүлж ирсэн байна.

ХЭХЗХ нь 2019-2023 оны хугацаанд 20 удаа хуралдаж 1271 хүүхдэд хууль зүйн үйлчилгээ үзүүлсэн байна.

График№9 ХЭХЗХ-с үйлчилгээ авсан хүүхэд



Аймгийн Цагдаагийн газар 2022 онд бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн сүүлийн 5 жилийн нөхцөл байдлын судалгааг хийсэн ба хохирогч, хүчирхийлэгчийн хамаарлын 90 орчим хувь нь өөрийн хойд эцэг, төрсөн эцэг, ах, дүү ойрын хамаатан саднууд байна. Суурь шалтгаан нь хараа хяналтгүй, бүтэн, хагас өнчин, архины хэт хамаарал, сэтгэцийн өөрчлөлттэй зэрэг нөхцөл байдал илэрсэн байна.

Хүснэгт№18 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийн судалгаа

Огноо	Хохирогч хүүхдийн тоо	Хүчирхийлэгч, хохирогчийн хамаарал			
		хойд эцэг	төрсөн ах, төрөл садан	эцэг эхийн танил, өөрийн найз	хөрш
2019	24	3	21		
2020	30	4	24	2	
2021	17	2	14	1	
2022	15		15		
2023	19	1	17		1
Нийт	105	10 (9,5%)	91 (86,6%)	3 (2,9%)	1 (1%)

Баянхонгор аймгийн хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, ГХУСАЗСЗ, аймгийн Цагдаагийн газраас 2019-2020 онд “Охидоо хамгаалъя” аян, “Сүүдэр бүү тусга” зөвлөгөөн зэрэг арга хэмжээнүүдийг Баянхонгор аймгийн 19 сум, аймгийн төвийн 10 багийн хамтарсан багтай хамтран хэрэгжүүлсэн байна.

Энэ арга хэмжээний хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газрын жирэмслэлт, үр хөндөлт, БЗХӨ-ний судалгааг ашиглан Цагдаагийн газар, аймгийн Эрүүл мэндийн газар, хамтарсан багуудын хамтын ажиллагааны үр дүнд сүүлийн жилүүдэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоог илрүүлж байгаа үзүүлэлт өндөр байна.

Энэ нь хүүхдийн эрх чөлөөнд заналхийлсэн аюултай үзэгдэл бөгөөд нэг талдаа түүнийг илрүүлж, таслан зогсоох ажил хийж байгаа нь чухал үзүүлэлт юм. Тухайлбал:

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх, эмэгтэйчүүдийн тасагт 14 настай А гэгч жирэмсэн үр хөндүүлсэн гэх дуудлага мэдээллийг гэмт хэргийн бүртгэлийн ... дугаарт бүртгэж, мөрдөн шалгах ажиллагааг явуулахад бэлгийн хүчирхийлэлд өртсөн нь тогтоогдож эрүүгийн хэрэг үүсгэгдэн шалгаж шүүхээр шийдүүлсэн байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 2019-2023 оны хугацаанд нийт 170 хүүхэд гэмт хэргийн хохирогч болж 164 хүүхэд гэмт хэрэгт холбогдож шийтгэгдсэн байна.

Хүснэгт №19 Гэмт хэрэгт хохирсон болон холбогдсон хүүхдийн судалгаа

Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Гэмт халдлагад өртөж хохирсон хүүхдийн судалгаа	38	34	25	25	48
Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн судалгаа	21	23	21	64	38
Дүн	59	57	46	89	86

Баянхонгор аймгийн ГХУСАЗСЗ-өөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, ялангуяа аймгийн хэмжээнд архидан согтуурахтай холбоотой үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох зорилгоор Баянхонгор аймаг архидан согтуурлаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлийн криминологи судалгааг 2022 он гаргаж, урьдчилан сэргийлэх бодлого стратеги боловсруулсан.

Архидан согтуурлаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлийн кримилогийн судалгааны үр дүнг 12 үндсэн чиглэлээр 81 үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвлөмж гаргасан байна.

Гэр бүл, хүүхэд залуучуудад чиглэсэн арга хэмжээнд 9 төрлийн үйл ажиллагааг 2021-2023 оны хугацаанд хэрэгжүүлэх зөвлөмжийг аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ, Цагдаагийн газар, ХГБХХГ, Эрүүл мэндийн газар, Боловсролын байгууллагууд хэрэгжүүлж ажилласан байна.

3.3.5. Салбар бүрд хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж эрсдэлийг бууруулж байна уу?

Хүүхэд хамгаалал, эрсдэлт нөхцлийн тоо мэдээ зөрүүтэй байгаагаас нь эрсдлийг бууруулсан эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаархи мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлохыг Хүүхэд хамгааллын тухай хуулиар тодорхойлсон.

ХГБХХГ нь 2019-2023 оны хугацаанд хамтарсан багаар дамжуулан хүүхдийн судалгааг авч сан бүрдүүлсэн боловч бодит байдалд дүн шинжилгээ хийж нэгтгээгүй байна. 2019 онд тоон судалгааг нь Баянхонгор сумыг хамруулан авсан байна.

Доорх судалгаанууд үндэсний статистикийн хорооноос гаргаж байгаа судалгаанаас зөрүүтэй байна.

Хүснэгт №20 ХГБХХГ-ын судалгааг статистик мэдээтэй харьцуулсан судалгаа

МД	Сонгосон үзүүлэлт	Аймгийн нийт дүн	Аймгийн нийт дүн	Аймгийн нийт дүн	Аймгийн нийт дүн	Аймгийн нийт дүн
		2023	2022	2021	2020	2019
Б	А	1		1	1	1
1	ХГБХХГ -ын судалгаа Бүтэн өнчин хүүхдийн тоо	68	114	79	82	39
1	Үндэсний статистикийн тоор бүтэн өнчин	58	67	75	81	79
2	ХГБХХГ -ын судалгаа Хагас өнчин хүүхдийн тоо	1258	1026	1038	1031	361
2	Үндэсний статистикийн тоо хагас өнчин	1145	1208	1060	820	
4	ХГБХХГ -ын судалгаа Дотуур байранд амьдарч буй хүүхдийн тоо	1521	1355	1536	1431	50
4	Үндэсний статистикийн тоо Дотуур байранд амьдарч буй хүүхдийн тоо	1870	1809	1548	1690	1770

Эрсдэлт нөхцөл байгаа хүүхдийн тоо мэдээлэл нь ХГБХХЕГ-аас ирүүлсэн судалгаанаас зөрүүтэй байна.

Аймгийн ХГБХХГ нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг тодорхойлохдоо 2019-2022 оны хугацаанд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-т заалтыг үндэслэсэн байна.

2023 онд эрсдэлт нөхцөл байгаа хүүхдийн судалгааг 2024 оны 9 дүгээр сарын 1-нд мөрдөж эхэлсэн Хүүхэд хамгааллын тухай шинэчилсэн хуулиар 4 орчныг нэмж оруулснаас шалтгаалж 2023 оны тоо мэдээлэл огцом өссөн байна.

График№10 Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгаа



Аудитаар нийт 133,8 сая төгрөгийн 12 зөрчил илэрч зөрчлийг арилгах 86.3 сая төгрөгийн 8 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 4 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

-оОо-

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутагт хүүхэд хамгааллын бодлогыг Монгол улсын урт дунд хугацааны бодлоготой уялдуулан боловсруулж нийгмийн зорилтод бүлэгт чиглэн ажилласан байна.
2. Аймгийн Хүүхэд гэр бүл, хөгжил хамгааллын газар нь хууль, дүрмээр хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж, мэдээллийн сан бүрдүүлэн ажилласан байна.
3. Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газар нь хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөхдөө үндэслэлтэй тооцоогүй, хуваарилалт оновчтой хийгээгүйгээс зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.
4. Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх салбарын онцлогт нийцсэн тусгай шалгуур үзүүлэлт бүхий аргачлал байхгүйгээс хяналтын үр нөлөө бүрэн гарахгүй байна.
5. Баянхонгор аймаг хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлснээр хүүхдүүд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, спортоор хичээллэх сонирхол нэмэгдэх эерэг хандлагатай байна.
6. Цахим орчинд хүүхэд эрсдэлд өртөж болзошгүй байдлыг хянах боломжгүй байна.
7. Хүүхдийн 108 утсанд дуудлага мэдээлэлд дүн шинжилгээ хийж шийдвэрлэж байгаа бөгөөд 2019-2023 оны хугацаанд дуудлага кейсийн шийдвэрлэлт дунджаар 91.8 хувьтай байна.
8. Санал асуулгын дүнгээс үзэхэд үе тэнгийн дээрхлэлт, ялгаварлан гадуурхалт байсаар байна.
9. Сумдын Хүүхдийн төлөө зөвлөл, Хамтарсан багийн ажиллагаа хангалтгүйгээс хүүхдийн эрхийн зөрчил гарсаар байна.
10. Хүүхэд хамгаалал, эрсдэлт нөхцөлийн тоо мэдээг холбогдох байгууллагууд өөрсдийн мэдээллийн эх үүсвэрээс гаргасан нь хоорондоо зөрүүтэй байна.

-оОо-

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Баянхонгор аймаг бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн тоогоор 2023 оны улсын хэмжээнд 2 дугаар байранд байгаа нь зайлшгүй анхааралд хандуулах асуудал болоод байна.
2. Цахим орчинд хүүхэд хамгаалах бодлого байхгүй байна.
3. ЕБС-ийн орчинд худалдаалж буй хориотой хүнс, электрон тамхины хэрэглээг судалсан судалгаа байхгүйгээс хяналтгүй задгай худалдаалагдаж байгаа нь хүүхдүүдийн эрүүл мэндэд аюул учирч болзошгүй байна.

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:

1. Сумдын хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан багийг чадавхжуулж, арга зүйгээр ханган хариуцлагыг сайжруулах арга хэмжээг сумын Засаг дарга нартай байгуулах гэрээнд тусгаж хэрэгжилтийг тооцох.

ГУРАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮҮХЭД ГЭР БҮЛ ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫН ГАЗРЫН ДАРГА Н.МЭНДБАЯР ТАНАА:

1. Сумдын хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан багийг арга зүйгээр хангах чадавхжуулах сургалтыг зохион байгуулж үр дүнг тооцох
2. Цахим орчинд хүүхэд хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг аймгийн бодлогод тусгаж, хэрэгжүүлэх
3. Холбогдох байгууллагуудын хүүхэд хамгаалал, эрсдэлт нөхцөлийн тоо мэдээний зөрүүтэй байдлыг арилгаж мэдээллийг нэгтгэх нэг сувагтай болох
4. Хүүхэд хамгааллын зардлыг арга хэмжээ бүрээр шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, нэгж хэмжих нэгтэйгээр тодорхой үндэслэлтэй төлөвлөж хэрэгжүүлэх.
5. ЕБС-ийн орчинд худалдаалж буй хориотой хүнс болон электрон тамхины хэрэглээг хязгаарлах арга хэмжээг шийдвэр гаргагч нарт танилцуулж, шийдвэрлүүлэх.
6. Хүүхдүүдийн дундах үе тэнгийн дээрхлэлт, ялгаварлан гадуурхалтыг үе шаттай бууруулах ажлыг зохион байгуулах.

ДӨРӨВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГА Ж.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА:

1. ЕБС-ийн орчинд худалдаалж буй хориотой хүнс болон электрон тамхины хэрэглээний талаар тандалт судалгаа хийж хүүхдийн асуудал хариуцсан Төрийн захиргааны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх.
2. Богд сумын ерөнхий боловсролын сургуулийн хэрэгжүүлж буй “Багш айлчлал хөтөлбөр”-ийн сайн жишээг аймгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлэх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

-оОо-

ҮАГ-Т ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Харин хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх салбарын онцлогт нийцсэн тусгай шалгуур үзүүлэлт бүхий аргачлал байхгүй байгаа тул энэ төрлийн аргачлалыг боловсруулах зөвлөмжийг Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын ерөнхий газарт хүргэх .